



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement.
bayankhongor@audit.gov.mn

2022.04.19 № 1/310
танай _____-ны № _____-т

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН СУМЫН Г
ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд баталгаажуулах аудит хийж, аудитын тайлан, дүгнэлтийг хүргүүлж байна.

Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлж, хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ



БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БНА-2022/1/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2022 оны 04 дүгээр сарын 19</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: Usukhbayarj@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: Amarjargalp@audit.gov.mn Аудитор: Л.Доржханд Утас: 99093683 Цахим хаяг: Dorjhandl@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	11
3.5.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	12
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	14
3.5.3 Авлага	14
3.5.4 Урьдчилгаа	17
3.5.5 Бараа материал	18
3.5.6 Үндсэн хөрөнгө	20
3.5.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	22
3.5.8 Өр төлбөр.....	22
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	25
ТӨҮГ болон ОНӨҮГ хувьд эздийн өмч дансанд гарсан өөрчлөлт.....	26
3.7 Шилэн дансны мэдээлэл.....	27
3.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	27
3.9 Аудитын гол асуудал	28
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	28
3.11 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	29
3.12 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	34
4. Аудитын илрүүлэлт.....	35
4.1 Залруулсан алдаа	35
4.3 Албан шаардлага	35
4.3 Зөвлөмж.....	37
5.Хавсралт 1.:Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	39
Хавсралт 2. Аудитаар өгсөн албан шаардлага	40
Хавсралт 2 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	50-57

Товчилсон үгийн жагсаалт

АОУС,	Аудитын олон улсын стандарт
АДБОУС,	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС,	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС,	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
СХАА,	Санхүүгийн хяналт аудитын алба
СТХС	Санхүү Төрийн сангийн хэлтэс
СХСан	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЦТ	Цахилгаан түгээх
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ХК	Хувьцаат компани
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн тэргүүлэгчдийн хурал
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар



Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ Г
ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement. bayankhongor@audit.gov.mn

2022.04.19 № 1/309

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Баянхонгор аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн Баянхонгор аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,030,466.4	43,838,459.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,519,210.4	17,802,382.5
33	АВЛАГА	7,902,594.3	10,641,444.7
34	УРЬДЧИЛГАА	186,387.6	276,916.8
35	БАРАА МАТЕРИАЛ	10,176,389.2	11,013,463.2
36	НӨӨЦИЙН БАРАА	3,245,885.0	4,104,252.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	215,896,775.6	246,947,259.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	215,896,775.6	246,947,259.5
39200	Биет хөрөнгө	198,440,927.4	229,326,237.8
39300	Биет бус хөрөнгө	17,455,848.2	17,621,021.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	246,927,242.0	290,785,718.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,293,337.6	14,913,633.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,634,050.4	7,444,139.5
41300	Өглөг	3,513,414.9	7,284,674.6
41400	Урьдчилж орсон орлого	120,635.4	159,464.9
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,659,287.2	7,469,493.7
42200	Урт хугацаат зээл	7,659,287.2	7,469,493.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	235,633,904.4	275,872,085.5
51	Засгийн газрын хувь оролцоо	235,633,904.4	275,872,085.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	93,143,246.6	95,482,032.0
51200	Хуримтлагдсан үр дүн	81,460,562.9	119,134,306.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зерүү	61,030,094.9	61,255,746.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	246,927,242.0	290,785,718.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	157,922,232.1	198,953,581.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	12,036,974.5	15,266,944.4
110	Орлогын албан татвар	8,897,915.9	10,064,284.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	9,350,646.7	10,519,199.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(452,730.8)	(454,914.2)
113	Хөрөнгийн албан татвар	1,005,608.8	1,085,868.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,133,449.8	4,116,791.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	112,539,774.2	136,163,316.0
120	Нийтлэг татварын бус орлого	38,776,854.7	62,068,637.1
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	73,762,919.5	74,094,678.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,345,483.4	47,523,320.7

Баянхонгор аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	145,710,219.8	161,639,902.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	145,710,219.8	161,639,902.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	138,221,155.1	155,068,418.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,987,776.8	46,523,356.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,563,886.4	6,102,546.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,146,062.9	9,061,153.1
2104	Хангамж, бараа материалын зардал	3,092,330.2	4,919,317.6
2105	Нормативт зардал	3,847,821.2	3,286,657.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	630,372.7	866,073.4
2107	Томилолт, зочны зардал	311,655.8	249,994.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,175,612.9	51,375,900.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,465,636.2	32,683,419.6
212	ТАТААС	835,559.5	835,994.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,653,505.2	5,735,488.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	12,212,012.3	37,313,678.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,713,481.8	1,321,307.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	10,498,530.5	35,992,371.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	139,497,712.2	161,713,703.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	12,036,974.5	15,206,923.8
110	Орлогын албан татвар	8,897,915.9	9,706,866.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	9,350,646.7	10,161,780.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-452,730.8	-454,914.2
113	Хөрөнгийн албан татвар	1,005,608.8	1,085,868.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,133,449.8	4,414,189.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	996,105.7	1,308,917.1
1181	Газрын төлбөр	346,542.6	1,162,161.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	761,251.8	1,916,808.4
1183	Бусад татвар	29,549.7	26,302.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,099,739.2	103,689,779.0
120	Нийтлэг татварын бус орлого	20,336,819.7	29,535,079.6
121	Хөрөнгийн орлого	0.0	60,020.6
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	73,762,919.5	74,094,678.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,360,998.6	42,817,000.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	101,728,108.9	110,665,011.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	101,728,108.9	110,665,011.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	94,143,626.2	102,630,246.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,808,885.2	46,900,520.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,637,338.4	6,115,270.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,131,153.1	9,068,984.6
2104	Хангамж, бараа материалын зардал	2,069,280.5	3,139,082.3
2105	Нормативт зардал	3,991,947.1	2,157,074.5

Баянхонгор аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	996,769.1	991,051.5
2107	Томилолт, зочны зардал	313,776.8	241,186.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,958,870.3	16,006,916.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,235,605.8	18,010,159.1
212	ТАТААС	944,316.4	2,266,919.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,640,166.4	5,767,845.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	37,769,603.3	51,048,692.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	36,094,254.7	42,765,519.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,094,254.7	42,765,519.9
2200	Дотоод эх үүсвэрээр	36,094,254.7	42,765,519.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-36,094,254.7	-42,765,519.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,675,348.6	8,283,172.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,843,861.7	9,519,210.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,519,210.4	17,802,382.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,538,367.4	209,538,367.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,708,257.8	1,708,257.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,246,625.2	211,246,625.2
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	13,888,748.7	13,888,748.7
9	Тайлант үеийн үр дүн	10,498,530.5	10,498,530.5
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,633,904.4	235,633,904.4
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	235,633,904.4	235,633,904.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,350,487.5	4,350,487.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	239,984,391.9	239,984,391.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-104,678.2	-104,678.2
19	Тайлант үеийн үр дүн	35,992,371.8	35,992,371.8
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	275,872,085.5	275,872,085.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	96,047,171.3	89,196,843.6	6,850,327.7	92.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,309,875.6	81,653,410.8	4,656,464.8	94.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,896,099.4	78,413,817.1	4,482,282.3	94.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,791,331.8	46,119,400.3	671,931.5	98.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,247,186.7	6,054,161.9	193,024.8	96.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,641,378.1	9,068,984.6	572,393.5	94.1
2104	Хангамж, бараа материалын зардал	3,376,269.0	3,207,472.3	168,796.7	95.0
2105	Нормативт зардал	2,511,383.3	2,159,340.7	352,042.6	86.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,227,684.8	2,199,547.6	28,137.2	98.7
2107	Томилолт, зочны зардал	269,141.3	240,288.6	28,852.7	89.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,619,051.7	1,499,994.9	119,056.8	92.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,212,672.7	7,864,626.1	2,348,046.6	77.0
212	ТАТААС	843,994.8	866,959.0	(22,964.2)	102.7
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	843,994.8	866,959.0	(22,964.2)	102.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,569,781.4	2,372,634.6	197,146.8	92.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	947,700.0	904,362.0	43,338.0	95.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,622,081.4	1,468,272.6	153,808.8	90.5

Баянхонгор аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,737,295.7	7,543,432.8	2,193,862.9	77.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	96,047,171.3	91,258,313.9	4,788,857.4	95.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,499,294.9	47,399,806.4	1,099,488.5	97.7
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,090,538.9	40,866,104.1	1,224,434.8	97.1
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	640,462.8	484,122.3	156,340.5	75.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,816,874.7	2,508,281.0	2,308,593.7	52.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,157,457.3	(2,157,457.3)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,218,927.6	(4,218,927.6)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	33,488.00	73,593.00	-40105	219.8
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	169	169	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3,951.00	3,931.00	20	99.5
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	25,417.00	24,850.00	567	97.8
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	19,287.00	19,352.00	-65	100.3
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	6,130.00	5,498.00	632	89.7
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	0	0	0	
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	0	40,712.00	-40712	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	3,951.00	3,931.00	20	99.5

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,917,718.6	9,588,633.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,911,745.6	9,573,052.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,277,304.5	6,860,662.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	20,672.5
2104	Хангамж, бараа материалын зардал	-	294.2
2105	Нормативт зардал	3,200.0	1,250.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	800.0	2,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,219,003.8	6,746,752.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,300.8	89,193.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,634,441.1	2,712,390.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,119,240.6	2,216,880.2
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	515,200.5	495,510.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,973.0	15,581.0
2200	Дотоод эх үүсвэрээр	5,973.0	15,581.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,917,718.6	9,588,633.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,917,718.6	9,588,633.4
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	-

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа ахлан аудитор Ж.Өсөхбаяр, П.Амаржаргал, Л.Доржханд нар гүйцэтгэж хяналтыг аудитын менежер А.Цээням, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 1а/181 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Засаг дарга нь “Бүтээх чадвартай өндөр мэргэшсэн ажиллах хүчнээр хангагдсан, унаган байгаль экологийн тэнцвэрийг хадгалж, байгаль орчныхоо онцлогт зохицсон, экспортод чиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээ хөгжсөн, хүний болон эдийн засгийн хөгжлөөрөө Монгол Улсын тэргүүлэх аймгуудын нэг болох” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн үйлчлэх хугацааг 2021.12.31-ыг дуустал сунгасан.
- Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-ыг шинэчлэн баталсан.
- Засгийн газрын 2021 оны 237 дугаар тогтоолоор Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны зардлыг шинэчлэн тогтоосон.
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны талаар гаргасан аймгийн Онцгой комиссын шийдвэрүүд
- Бусад хууль, тогтоол, журам заавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хороо 2021 онд Аймгийн замын сан, Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Сумдын сум хөгжүүлэх сангийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын үр дүнг танилцуулж 3 тогтоолыг гаргуулан холбогдох газруудад хүргүүлэн биелэлтийг тооцсон байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2021 оны байдлаар төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт-17, дотоод аудит-7, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 2, захирамж 7 нийт 33 санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг хийж 67 заалт бүхий 24 зөвлөмж хүргүүлэн, улсын ахлах байцаагчийн 348.5 сая төгрөгийн төлбөрийн актын тогтоож, тухайн байгууллагын орлогод 158.5 сая төгрөг, орон нутгийн төсөвт 90.9 сая төгрөг, хуулийн байгууллагад 8.5 сая төгрөг тус тус төвлөрч төлбөрийн актын барагдуулалт 92.4 хувьтай байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 161,626.9 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 808.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 525.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 290,785.7 сая төгрөг болж өмнөх оноос 17.8 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр/өмч

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Дүнд эзлэх хувь	
				Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Эргэлтийн хөрөнгийн дүн	31,030.5	43,838.5	12,808.0	12.6	15.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	215,896.8	246,947.3	31,050.5	87.4	84.9
Нийт хөрөнгийн дүн	246,927.2	290,785.7	43,858.5	100.0	100.0
Нийт өр төлбөр	11,293.3	14,913.6	3,620.3	4.6	5.1
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	235,633.9	275,872.1	40,238.2	95.4	94.9
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	246,927.2	290,785.7	43,858.5	100.0	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Баянхонгор аймгийн ТӨЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 9,519.2 сая, эцсийн үлдэгдэл 17,802.4 сая төгрөг болж, өмнөх оноос 8,283.2 сая төгрөгөөр буюу 87.0 хувиар өссөн байна. Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 16,867.3 сая буюу 94.7 хувь нь касс болон төрийн сангийн харилцах дансанд, 935.1 сая буюу 5.3 хувь нь арилжааны банканд байршиж байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банканд байгаа бэлэн мөнгө		Өсөлт (+), Бууралт (-)
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс	
Кассад байгаа бэлэн мөнгө	1.1	3.2	3.2	-	-	2.1
Төгрөг/ ЖМС	1.1	3.2	3.2	-	-	2.1
Нэмэлт санхүүжилтийн Касс	-	-	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	9,518.1	17,799.2	-	935.1	16,864.1	8,281.1
Төгрөг	9,518.1	17,799.2	-	935.1	16,864.1	8,281.1
Гадаад валют	-	-	-	-	-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-	-	-
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	9,519.2	17,802.4	3.2	935.1	16,864.1	8,283.2
<i>Үүнээс байгууллагын төрлөөр:</i>						
Төрийн сан	3,610.6	5,395.6	-	-	5,395.6	1,784.9
Төсөвт байгууллагууд /ОНХС, СХС, Замын сан/	2,157.5	4,218.9	-	3.5	4,215.4	2,061.5
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	749.3	933.9	3.2	930.8	-	184.6
Төсөл, сангууд	3,001.8	7,253.9	-	0.9	7,253.1	4,252.2

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

1. Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө оны эхэнд 3,610.6 сая төгрөг байснаас оны эцэст 5,395.6 сая төгрөг болж өмнөх оноос 1,784.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь орон нутгийн давсан орлогын зарцуулагдаагүй 4,139.3 сая, төсөвт байгууллагуудын харилцах дансны зарцуулагдаагүй үлдэгдлийг Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн 533.9 сая, урьд оны харилцах дансны 722.4 сая төгрөгийг зарцуулаагүйгээс нийт 5,395.6 сая төгрөг байна.

Хүснэгт 3. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс			Өсөлт (+), Бууралт (-)
			Орон нутгийн давсан орлого	Буцаан төвлөрүүлэлт	Урьд оны зарцуулаагүй үлдэгдэл	
Галуут	61.8	158.9	61.8	20.0	77.1	97.1
Баян-овоо	47.9	10.1	-	4.2	5.8	(37.8)
Эрдэнэцогт	83.1	201.6	110.3	33.1	58.2	118.5
Бууцагаан	114.8	57.5	40.0	3.6	14.0	(57.3)
Жинст	40.3	22.2	11.9	4.4	5.9	(18.1)
Богд	55.0	91.0	61.1	22.4	7.5	36.0
Баянлиг	61.1	72.6	24.1	32.5	16.0	11.5
Баянговь	53.3	41.8	28.8	3.8	9.2	(11.5)
Гурванбулаг	105.2	216.9	144.5	12.8	59.6	111.7
Жаргалант	47.8	189.0	162.7	24.3	2.0	141.2
Заг	59.5	293.8	233.7	41.5	18.7	234.3
Баацагаан	28.9	25.3	9.2	15.1	1.0	(3.7)
Бөмбөгөр	169.9	118.1	102.4	7.0	8.6	(51.8)
Өлзийт	62.7	504.2	385.8	111.2	7.1	441.5
Хүрээмарал	60.8	90.7	18.9	44.9	26.9	30.0
Баянбулаг	90.9	57.0	39.9	12.4	4.7	(33.9)
Шинэжинст	81.7	116.5	74.7	19.5	22.3	34.7
Баянцагаан	53.1	54.7	25.0	25.2	4.4	1.6
Баян-өндөр	125.2	67.9	18.4	32.5	17.0	(57.3)
Баянхонгор	359.4	292.2	270.3	19.3	2.6	(67.2)
Сумын дүн	1,762.2	2,681.7	1,823.3	489.7	368.7	919.5
Баянхонгор аймаг	1,848.5	2,713.9	2,316.1	44.2	353.7	865.4
Нийт дүн	3,610.6	5,395.6	4,139.3	533.9	722.4	1,784.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст төсвийн ерөнхий орлогын данс 5,395.6 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс 2,681.7 сая төгрөг нь 20 сумын орон нутгийн төсвийн ерөнхий орлогын

дансны үлдэгдэл бөгөөд оны эцэст аймгийн төвийн төсөвт байгууллагууд зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлснээс 44.2 сая, төлөвлөгөөнөөс давсан орлого болон урьд оны зарцуулаагүй үлдэгдэл 2,669.7 сая, нийт 2,713.9 сая төгрөг аймгийн орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээр байна.

2. Төсөвт байгууллага, сангийн мөнгөн хөрөнгө:

Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,157.5 сая, эцсийн үлдэгдэл 4,218.9 сая төгрөг болж, өмнөх оноос 2,061.5 сая төгрөгөөр өссөн ба сум хөгжүүлэх сангийн 2,529.3 сая, орон нутгийн хөгжлийн сангийн 1,642.8 сая, замын сангийн 43.3 сая, өрхийн эмнэлгүүдийн харилцах дансны үлдэгдэл 3.5 сая төгрөг байна.

Сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл өмнөх оноос 1,051.5 сая төгрөгөөс өссөн нь сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг олгоогүйтэй холбоотой байгаа бол Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1,001.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь зарим сумд төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Хүснэгт 4. Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Сумын нэр	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		Сумын нэр	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
	СХСан	ОНХСан		СХСан	ОНХСан	Замын сан	Өрхийн эмнэлгүүд
Галуут	135.2	47.9	Баацагаан	101.3	93.8	-	-
Баян-Овоо	92.9	11.5	Бөмбөгөр	79.7	142.9	-	-
Эрдэнэцогт	68.1	49.6	Өлзийт	55.5	28.6	-	-
Бууцагаан	100.3	94.8	Хүрээмарал	63.9	56.4	-	-
Жинст	67.1	0.5	Баянбулаг	86.0	55.4	-	-
Богд	100.6	18.1	Шинэжинот	91.7	113.8	-	-
Баянлиг	186.1	176.6	Баянцагаан	114.9	118.7	-	-
Баянговь	165.8	119.2	Баян-Өндөр	89.0	176.5	-	-
Гурванбулаг	59.3	70.8	Баянхонгор сум	729.1	64.4	-	-
Жаргалант	57.5	19.0	Аймгийн ОНХС	-	172.1	-	-
Заг	85.3	12.2	Аймаг	-	-	43.3	3.5
Нийт дүн			2,529.3	1,642.8	43.3	3.5	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3. Төсөл сангийн мөнгөн хөрөнгө:

Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 4,252.9 сая төгрөгөөр өсөж, 7,253.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 6,212.2 сая төгрөг нь улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээнээс тооцсон барьцаа, ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн Барилгын тухай хуульд заасан баталгаат хугацааны баталгаа болон улсын төсвөөс хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний дутуу олгосон санхүүжилт байгаа бол 529.5 сая төгрөг нь улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээнээс суутган тооцсон хяналтын зардал болон бусад зардлын зарцуулаагүй үлдэгдэл, орон нутгийн нөөц сангийн дансны үлдэгдэлд байгаа 512.2 сая төгрөг нь төсвийн байгууллагуудын нэмэлт дансны буцаан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэл байна.

Хүснэгт 5. Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутгийн нөөц сан	496.2	512.2	16.0	7.1
Барьцаа хөрөнгийн данс	2,504.9	6,212.2	3,707.3	85.6
Техник хяналт данс	-	529.5	529.5	7.3
Нийт дүн	3,001.1	7,253.9	4,252.8	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7¹-т заасны дагуу ТШЗ-ийн 53 байгууллага нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдэл 512.2 сая төгрөгийг оны эцэст орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

¹ Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

Дээрх үлдэгдлээс 15 байгууллагын 237.0 сая төгрөгийн үлдэгдлийг аймгийн Засаг даргын 2022.02.15-ны өдрийн А/88 дугаар захирамжаар төсөв захирагч нарт зарцуулах эрхийг нь нээж өгсөн ба үлдэгдэл 275.0 сая төгрөгийг төсвийн захирагч нартай санхүүгийн тайлан хүлээж авахдаа тооцоо нийлж баталгаажуулан орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Харин санхүүгийн нэгтгэсэн тайланд төсөвт байгууллагуудад олгох 237.0 сая төгрөгийн өглөгөөс 119.7 сая төгрөгийн өглөгийг тусгаж 117.3 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг аудитын явцад залруулав.

4. Арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгө:

Арилжааны банканд байршиж байгаа мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 775.0 сая, эцсийн үлдэгдэл 935.1 сая төгрөг болж, 160.2 сая төгрөгөөр өссөн бөгөөд үлдэгдлийн 99.5 хувийг ТӨҮГ болон ОНӨААН-ийн үлдэгдэл, 0.1 хувийг төсөл сангийн үлдэгдэл, 0.4 хувийг төсөвт байгууллага эзэлж байна.

Хүснэгт 6. Арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	26.0	3.5	(22.5)	0.4
Төсөл/ сан	0.7	0.9	0.2	0.1
Төрийн сан	-	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	748.2	930.8	182.6	99.5
Дүн	774.9	935.1	160.2	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТӨҮГ болон ОНӨҮГ-ийн харилцах дансны үлдэгдэл 930.8 сая төгрөг байгаагаас “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн харилцах дансны үлдэгдэл 460.1 сая, “Чандмань Баянхонгор” ХК-ийн үлдэгдэл 79.1 сая, “Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн үлдэгдэл 281.2 сая төгрөг байгаа нь голлох нөлөөг үзүүлж байна.

Төсөвт байгууллагын арилжааны банкны үлдэгдэл 3.5 сая төгрөг байгаа нь аймгийн төвийн 4 өрхийн эмнэлгийн харилцах дансны үлдэгдэл байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Баянхонгор аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат хөрөнгө оруулалт байхгүй.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 7,902.6 сая, эцсийн үлдэгдэл 10,641.4 сая төгрөг болж, 2,738.8 сая төгрөгөөр өссөн бөгөөд нийт авлагын 45.2 хувь буюу 3,574.8 сая төгрөгийг сумдын ЭМТ-ийн татаас санхүүжилтийн авлага, 57.7 хувь буюу 4,559.9 сая төгрөгийн сумдын сум хөгжүүлэх сан, Үйлдвэржилт хөгжлийн корпорацийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр олгосон зээлийн авлага эзэлж байна.

Хүснэгт 7. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Ангилал	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), бууралт (-)	Хувь
Ажилчидтай холбогдсон авлага	35.9	94.4	58.5	1.2
Төлбөрт үйлчилгээний авлага	45.7	25.7	(20.0)	0.3
Татаас, санхүүжилтийн авлага		3,574.8	3,574.8	45.2
Зээлийн хүүгийн авлага	2.4		(2.4)	-
Дансны авлага /ТӨҮГ/	0.06	54.4	54.3	0.7
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/			-	-
Бусад авлага	2,083.5	2,332.2	248.7	29.5
Зээлийн авлага	5,735.0	4,559.9	(1,175.2)	57.7
Дүн	7,902.6	10,641.4	2,738.8	134.7
Үүнээс байгууллагын төрлөөр:			-	-
Төсөвт байгууллага	5,408.1	9,829.2	4,421.1	92.4

Төсөл/сан			-	
Төрийн сан			-	
ТӨҮГ болон ОНӨҮГ	2494.5	812.2	(1,682.3)	7.6
Нийт дүн	7,902.6	10,641.4	2,738.8	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жил болсон насжилт өндөртэй 666.6 сая төгрөгийн авлага өмнөх оны үлдэгдлээр байсан бөгөөд тайлант онд Чандмань Баянхонгор” ХК-ийн санхүүгийн тайланд 2010 оноос хойш шийдвэрлэгдээгүй Хот тохижилттой холбоотой 22.4 сая, аймгийн ЗДТГ-ын бор балгасын усжуулалтын системтэй холбоотой 11.4 сая төгрөгийн нийт 33.8 сая төгрөгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.02.01-ны өдрийн 23 дугаар тогтоолоор данснаас хасаж зардлаар бүртгэн авлагыг барагдуулсан байна. Мөн Шинэжинст сумын хүүхдийн Цэцэрлэгийн 2012 онд үүссэн “Ган мөнхжин” ХХК-аас авах зураг төсвийн 2.7 сая төгрөгийн авлага барагдаагүй үлдэгдлээр байсныг тус байгууллагын эрхлэгчийн 2021.12.15-ны өдрийн 54 тушаалаар зардлаар бүртгэж авлагыг барагдуулсан байна.

Харин тайланд онд насжилт өндөртэй 748.2 сая дараах авлагууд байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-аар дамжуулан олгосон 3-аас дээш жилийн насжилттай хугацаа хэтэрсэн 60 зээлдэгчийн 741.5 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл;
- Хүрээмарал сумын ЗДТГ-ын 2011 онд үүссэн дизель мотор түрээслүүлсний 3.0 сая төгрөгийн авлага;
- Аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2005 онд үүссэн аймгийн “Цахилгаан холбоо” ХК-аас авах 1.1 сая төгрөгийн авлага;
- Гурванбулаг сумын Иргэдийн төлөөлөгчийн хурлын хувь хүнээс авах 2.0 сая төгрөгийн авлага;
- Гурванбулаг сумын 2002 онд үүссэн Ерөнхий боловсролын сургуулийн нярваар ажиллаж байсан иргэнтэй холбоотой 0.6 сая төгрөгийн авлага;

Дээрх олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар холбогдох байгууллагууд тодорхой хэмжээний арга хэмжээг авч ажилласан ч олон жил болсноос эзэн холбогдогч нь тодорхойгүй болсон зэргээс шалтгаалан шүүх хяналтын байгууллага хүлээн боломжгүй байдаг зэрэг тайлбарыг холбогдох байгууллага нь өгч байгаа тул тодорхой арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

Насжилт өндөртэй авлага нь өмнөх оноос 89.6 сая төгрөгөөр өссөн нь Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацын 3-аас дээш жилийн насжилттай авлагыг хамруулсантай холбоотой болно.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангаарх авлагын 45.2 хувь буюу 3,574.8 сая төгрөгийн авлага нь сумдын ЭМТ-ын татаас санхүүжилтийн авлага байгаа бөгөөд тус авлага нь ковид-19 цар тахал өвчинтэй холбоотойгоор үүссэн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлага байгаа нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 8. Санхүүжилтийн авлага /сая төгрөг/

№	Сумдын нэр	Эрүүл мэндийн төвүүдийн санхүүжилтийн авлага			
1	Галуут	284.4	11	Заг	178.3
2	Баян-Овоо	110.7	12	Баацагаан	177.4
3	Эрдэнэцогт	49.8	13	Бөмбөгөр	313.4
4	Бууцагаан	327.1	14	Өлзийт	101.7
5	Жинст	172.2	15	Хүрээмарал	154.0
6	Богд	130.5	16	Баянбулаг	110.2
7	Баянлиг	185.7	17	Баян-Өндөр	161.4
8	Баянговь	184.6	18	Баянцагаан	106.3

Баянхонгор аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

9	Гурванбулаг	310.7	19	Шинэжинст	133.3
10	Жаргалант	341.3	20	Баянхонгор	41.8
НИЙТ					3,574.8

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Санхүүгийн тайланг э-тайланд шивэхдээ нягтлан бодогч нар авлагаа насжилтаар нь ангилан шивдэггүй нийтлэг зөрчил байна. Энэ тус программыг авлага дансны хувь бүрэн ашиглахгүй байгааг харуулж байна.

Тухайлбал

• Тайлант онд үүссэн 3,574.8 сая ЭМТ-ын татаас санхүүжилтийн авлага нь э-тайлангийн авлагын тодруулга тайлангийн насжилтаар авч үзэхэд 0-1 жилийн насжилттай авлагат 642.2 сая, 5-аас дээш жилийн насжилттай авлагат 2,770.9 сая төгрөгийг өндөр насжилттай авлагаар харагдаж байгаа нь нягтлан бодогчид э-тайлангийн авлагын тодруулга тайланд авлагаа насжилтаар нь тайлагнаагүйтэй холбоотой байна. Аудитын явцад авлагын тодруулга тайлангийн авлагын насжилтыг залруулан э-тайланд бүртгүүлэв.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 4,559.9 сая төгрөг зээлийн авлага байгаа бөгөөд үүний 41.4 хувь нь буюу 1,888.1 сая төгрөг нь “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК буюу жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгож буй хөнгөлөлттэй зээлийн авлага, 58.6 хувь буюу 2,671.8 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагууд байна.


Хүснэгт 9. Зээлийн авлага /сая төгрөг/

Байгууллагын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Сум хөгжүүлэх сан	3636.9	2,671.8	-965.1
“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК	2038.7	1,888.1	150.6
Дүн	5675.6	4,559.9	-1,115.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн авлага 2021 оны эхний үлдэгдэл 3636.9 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 2,671.8 сая төгрөг болж 965.0 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ТТЗ-ийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх, заасан хугацаанд төлөөгүй иргэн, аж ахуйн нэгжийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зөвлөмжийг сумын Засаг дарга нарт хүргүүлсэн мөн тайлант онд тус сангаас зээл олголт хийгдээгүйтэй холбоотой байгаа ба энэ хэмжээгээр СХС-гийн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,529.3 сая төгрөгт хүрч өмнөх оноос 1051.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2021 ОНЫ СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН АВЛАГА



Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл нь Баянхонгор сум хамгийн өндөр буюу 238.0 сая, Баянговь сум хамгийн бага буюу 48.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бол авлагатай байна.

Хүснэгт 10. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага сумдаар /сая төгрөг/

№	Сумын нэр	Хувь хүмүүст олгосон зээлийн авлага		№	Сумын нэр	Хувь хүмүүст олгосон зээлийн авлага	
		Өмнөх он	Тайлант он			Өмнөх он	Тайлант он
1	Баянбулаг	191.6	119.5	11	Баян-Өндөр	157.6	149.3

Баянхонгор аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

2	Баянговь	79.0	48.2	12	Галуут	200.7	119.7
3	Богд	129.5	102.3	13	Гурванбулаг	162.2	144.8
4	Баянлиг	134.4	69.4	14	Жаргалант	190.8	197.8
5	Баян-Овоо	159.3	79.2	15	Жинст	131.9	123.8
6	Бөмбөгөр	159.5	105.0	16	Заг	126.7	107.9
7	Бууцагаан	213	134.9	17	Хүрээмарал	183.7	132.6
8	Баянхонгор	563.4	325.4	18	Шинэжинст	176.1	111.8
9	Баацагаан	233.5	155.6	19	Эрдэнэцогт	126.1	114.1
10	Баянцагаан	197.3	140.7	20	Өлзийт	120.5	189.8
НИЙТ ДҮН		2060.5	1280.2		НИЙТ ДҮН	1576.3	1391.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ОНХС-ийн санхүүгийн тайланд бүртгэлтэй авлагын эхний үлдэгдэл 855.0 сая төгрөг байсан ба тайлант онд 958.6 сая төгрөг болж өмнөх оноос 103.6 сая төгрөгөөр нэмэгдсэн ба нийт авлагын 31.5 хувь буюу 302.0 сая төгрөг нь малжуулах зээлийн авлага, 44.8 хувь буюу 429.1 сая төгрөг нь зураг төсвийн үнийн авлага, 3.8 хувь 36.8 сая төгрөг нь өвс тэжээлийн авлага, 2.4 хувь буюу 23.1 сая төгрөг нь бусад авлага байна.

Хүснэгт 11. ОНХС-ийн авлага /сая төгрөг/

Сумдын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Авлагын эцсийн үлдэгдлийн бүтэц				
				Зураг төсвийн үнэ	Малжуул-ах зээлийн авлага	Хөрөнгө, материал бэлтгэх олгосон урьдчилгаа	Өвс тэжээл	Бусад
Баянхонгор аймаг	194.3	429.1	234.8	429.1				
Баян-овоо	17.1	34.1	17.0		16.8			17.3
Эрдэнэцогт	1.6	11.6	10.0				11.6	
Богд	55	55.0	-					
Баянлиг	6.3	3.8	(2.5)				3.8	
Баянговь	178.3	70.6	(107.7)		30.7			
Гурванбулаг	136.6	129.6	(7.0)		129.6			
Заг	0.2	2.0	1.8					2.0
Баацагаан	109.7	105.1	(4.6)		87.9		17.2	
Өлзийт	7.6	4.2	(3.4)				4.2	
Хүрээмарал	76.5	76.5	-					
Баян-өндөр	68.0	37.0	(31.0)		37.0			
Баянхонгор сум	3.8	-	(3.8)					3.8
Нийт	855.0	958.6	103.6	429.1	302.0	-	36.8	23.1

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 186.4 сая, эцсийн үлдэгдэл 276.9 сая төгрөг болж, өмнөх оноос 90.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 12. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Хувь
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	185.4	275.2	89.8	99.4
Цалингийн урьдчилгаа	1.0	1.7	0.7	0.6
Дүн	186.4	276.9	90.5	100.0
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	1.0	1.7	0.7	0.6
ТӨҮГ болон ОНӨҮГ	185.4	275.2	89.8	99.4
Дүн	186.4	276.9	90.5	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд бүртгэгдсэн 276.9 сая төгрөгийн үлдэгдлээс 275.2 сая төгрөг нь “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой 2021 онд төлөвлөгдсөн дутуу хийж гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын ажлын урьдчилж гарсан зардал

болох 249.4 сая, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авахаар урьдчилсан төлсөн зардал 25.4 сая, бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа 0.4 сая төгрөг бүртгэгдсэн байна.

Харин цалингийн урьдчилгааны 1.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байгаа нь Гурванбулаг сумын ЭМТ-ийн 1.1 сая, Баянбулаг сумын цэцэрлэгийн 0.3 сая төгрөгийн цалингийн урьдчилгааны авлага тайлант онд үүссэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант онд “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК -ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021.01.29-ний өдрийн “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК -ийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” 02 дугаар тогтоолоор баталсан “Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төлөвлөгөө”-ний 3.3-т заасан “ЦШС-ШҮ-ын албанд шугамын трассын дагуу туулах чадвартай автомашин худалдаж авах” арга хэмжээний хүрээнд Таван богд ХХК-д 130.0 сая төгрөгийг 2021 оны 11, 12 дугаар сард 3 хуваан шилжүүлэн урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021.02.17-ын өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4 дэх “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

ТЕЗ-ийн харьяа ОНӨААН-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

3.5.5 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 10,176.4 сая төгрөг байсан ба оны эцэст үлдэгдэл 11,013.5 сая төгрөг болж, 8.2 хувиар буюу 837.1 сая төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 265.4 сая, эм боох материал 340.2 сая, дуусаагүй үйлдвэрлэл 188.5 сая, аж ахуйн материал 429.5 сая төгрөгөөр тус тус өмнөх оноос өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Нөөцийн барааны эхний үлдэгдэл 3,245.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,104.3 сая төгрөг болж 858.4 сая төгрөгөөр өссөн нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр дутуу хэрэгжсэн ажлуудын олгосон санхүүжилт 712.1 сая, Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр дутуу хэрэгжсэн ажлуудын олгосон санхүүжилт 226.8 сая төгрөгөөр өмнөх оноос нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 13. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалтын материал	1,779.8	2,045.2	265.4	13.5
Эм боох материал	197.4	537.6	340.2	3.6
Дуусаагүй үйлдвэрлэл	193.5	382.0	188.5	2.5
Бэлэн бүтээгдэхүүн	37.2	90.7	53.4	0.6
Бичиг хэргийн материал	210.3	245.8	35.5	1.6
Аж ахуйн материал	3,134.8	3,564.3	429.5	23.6
Сэлбэг хэрэгсэл	34.6	61.6	27.0	0.4
Түлш, шатах тослох материал	62.4	44.6	(17.9)	0.3
Барилгын засварын материал	167.8	162.7	(5.0)	1.1
Хүнсний материал	30.1	89.6	59.5	0.6
Бусад хангамжийн материал	4,136.8	3,598.2	(538.6)	23.8
Мал амьтад	191.8	191.3	(0.5)	1.3
Бараа материалын дүн	10,176.4	11,013.5	837.1	72.9
Нөөцийн бараа	3,245.9	4,104.3	858.4	27.1
НИЙТ ДҮН	13,422.3	15,117.7	1,695.4	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст төсөвт байгууллагуудын тусгай зориулалтын материал 265.4 сая, эм боох материал 340.2 сая төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотой эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн материал авч нөөц бүрлүүлсэнтэй холбоотой байгаа бол дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл 188.5 сая төгрөгөөр өссөнд

Баацагаан, Шинэжинст сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дутуу хэрэгжсэн ажлуудын олгосон санхүүжилт 168.3 сая төгрөгийг бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 96.9 хувийг төсөвт байгууллага, 3.1 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал тус тус эзэлж байна.

Хүснэгт 14. Бараа материалын хөдлөл өөрчлөлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), Бууралт (-)
Эхний үлдэгдэл	10,512.2	13,422.3	2,910.1
<i>Нэмэгдсэн</i>	<i>13,327.9</i>	<i>15,964.3</i>	<i>2,636.4</i>
Худалдан авсан	11,822.5	13,245.8	1,423.3
Хандиваар	373.5	669.4	295.8
Шилжүүлэн авсан	707.8	859.4	151.6
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр		153.4	153.4
Бусад	424.0	1,036.2	612.2
<i>Хасагдсан</i>	<i>10,417.8</i>	<i>14,268.8</i>	<i>3,851.1</i>
Худалдсан, зарцуулсан	9,125.0	13,027.2	3,902.2
Шилжүүлсэн	698.4	459.1	(239.3)
Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	0.2	18.7	18.6
Бусад /Акталсан/	594.2	763.8	169.6
Эцсийн үлдэгдэл	13,422.3	15,117.7	1,695.4
Үүнээс, байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	13,004.2	14,640.1	1,635.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	418.0	477.6	59.6
Дүн	13,422.3	15,117.7	1,695.4

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 13,245.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандив тусламжаар 669.4 сая, балансаас баланст 2,049.0 сая төгрөгийн материал шилжүүлэн авч, нийт 15,964.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 13,027.2 сая төгрөгийн хөрөнгийг үйл ажиллагаандаа зарцуулан, 477.9 сая төгрөгийн бараа материалыг балансаас баланст шилжүүлж, 763.8 сая төгрөгийн бараа материалыг актальж нийт 14,268.8 сая төгрөгөөр хасагдсан байна.

Баянхонгор аймгийн ТЭЗ-ийн харьяа ТШЗ-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд бараа материалыг анхан шатны баримтаар үнэн зөв, ангилан бүртгэл хөтөлдөггүй, бараа материалын шинж чанаргүй нэг удаагийн зардлыг орлогоор авч зарлагаддаг, тооллого тооцоог хийж баталгаажуулаагүй, шийдвэр гаргаагүйгээр актальж данснаас хасдаг, оны эцэст их хэмжээгээр худалдан авалт хийж нөөц үүсгэсэн зэргээр бараа материалын данстай холбоотой нийт 348.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

ТШЗ-ийн аудитаар илэрсэн зөрчлийн ангилал



Тухайлбал:

- Байгаль орчин аялал жуулчлалын газар, Баянхонгор сумын 11, 7, 15 дугаар цэцэрлэг, Эрдэм ахлах сургууль зэрэг 14 байгууллага бараа материалын тайланг сар бүр анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв гаргаагүй;
- Баянхонгор аймгийн сум дундын ойн анги, Баянхонгор сумын Эрдэм ахлах сургууль, Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургууль зэрэг 3 байгууллага жилийн эцэст хөрөнгийн тооллогыг иж бүрэн хийж баталгаажуулаагүй, орлого, зарлагын анхан шатны баримт дутуу;
- Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургууль 2.1 сая төгрөгийн хөрөнгийг хүлээж аваагүй, Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэг нь 37.5 сая төгрөгийн хөрөнгийн орлого, зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй;

- Бууцагаан ЗДТГ нь хөрөнгө актлах тухай удирдлагын шийдвэр гараагүй байхад нийт 20.6 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг актлаж данснаас хассан;
- Баянхонгор сумын 9, 10 дугаар цэцэрлэг, Богд, Жинст сумын цэцэрлэг, Жинст сумын сургууль нь оны эцэст нийт 10.8 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг худалдан авч нөөц үүсгэсэн;
- Байгаль орчин аялал жуулчлалын газар, Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэг, Эрдэм ахлах сургууль, Баян-Ойт цогцолбор сургууль, Баянхонгор аймгийн сум дундын ойн анги зэрэг 22 байгууллага 165.5 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг зөв ангилж бүртгээгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 275,576.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 318,855.5 сая төгрөг болж 43,279.3 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүнээс төсөвт байгууллагын үндсэн хөрөнгө 41,826.2 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөө үзүүлж байна.

Нийт үндсэн хөрөнгийн 94.4 хувийг биет хөрөнгө, 5.6 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна. Биет бус хөрөнгийн эцсийн үлдэгдэл 17,940.2 сая төгрөг болж өмнөх оноос 225.3 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 1.5 хувийг программ хангамж, 98.5 хувийг газар буюу бусад биет бус хөрөнгө эзэлж байна.

Хүснэгт 15. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Хувь
Барилга байгууламж, орон сууц	196,207.0	230,726.3	34,519.3	72.4
Тээврийн хэрэгсэл	8,731.9	9,246.1	514.1	2.9
Машин тоног төхөөрөмж	21,875.6	26,317.2	4,441.6	8.3
Тавилга эд хогшил	9,234.7	10,229.2	994.5	3.2
Зам гүүрний барилга байгууламж	846.5	2,651.4	1,804.9	0.8
Түүх соёлын дурсгалт зүйл	963.7	968.0	4.3	0.3
Дуусаагүй барилга байгууламж	1,565.5	1,546.5	(19.0)	0.5
Номын фонд	1,006.6	1,050.0	43.4	0.3
Бусад үндсэн хөрөнгө	17,429.8	18,180.6	750.8	5.7
Программ хангамж	238.6	273.9	35.3	0.1
Бусад биет бус хөрөнгө	17,476.3	17,666.3	190.0	5.5
Дүн	275,576.2	318,855.5	43,279.3	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2,799.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 20,502.4 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст, 4,392.1 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн, 1,118.0 сая төгрөгийг хандиваар авч, бусад эх үүсвэрээс 17,672.7 сая, төгрөгийн хөрөнгө нэмэгдэн, дахин үнэлгээний 40.8 сая төгрөгийн нэмэгдэл бүртгэж нийт 46,525.1 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, 3,245.9 сая төгрөгийн хөрөнгө хасагдсанаас 1,526.5 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 1,402.5 сая төгрөгийн хөрөнгийг актлан, 1.0 сая төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулж, бүтцийн өөрчлөлтөөр 315.9 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн байна.

Хүснэгт 16. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Биет хөрөнгийн дүн	Биет бус хөрөнгийн дүн	Нийт хөрөнгийн дүн
Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	257,861.3	17,714.9	275,576.2
Нэмэгдсэн	46,234.9	290.2	46,525.1
Худалдан авсан	2,732.9	66.2	2,799.1
Хандиваар	1,118.0	-	1,118.0
Шилжүүлэн авсан	20,482.4	20.0	20,502.4
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	4,339.8	52.3	4,392.1
Бусад	17,521.0	151.7	17,672.7
Дахин үнэлгээний нэмэгдэл	40.8	-	40.8
Хасагдсан	3,181.0	64.9	3,245.9
Худалдсан	1.0	-	1.0
Акталсан	1,399.2	3.3	1,402.5
Шилжүүлсэн	1,466.5	60.0	1,526.5
Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	314.3	1.6	315.9

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	300,914.5	17,940.2	318,854.7
----------------------------------	-----------	----------	-----------

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр гэсэн орлогын зүйлээр тайлант онд 4,339.8 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнд ЭМС-ын 2019.11.29-ны өдрийн А/540 дугаартай “Журам, шалгуур үзүүлэлт жагсаалт батлах тухай” тушаалын дагуу Баянцагаан, Богд, Жаргалант сумдын Сум дундын эмнэлгүүдийг сумын Эрүүл мэндийн төв болгон статусыг өөрчлөн тайланг аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэнтэй холбоотой 4,183.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн бусад хэсэгт нэмэгдсэн 17,672.7 сая төгрөг нь Жинст сумын сургуулийн 3,341.5 сая төгрөгийн барилга, Орон нутгийн өмчийн газрын тайланд 2,340.6 сая төгрөгийн Баянхонгор сумын гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, Бууцагаан, Эрдэнэцогт, Жинст, Заг, Шинэжинст сумдын нийт 7,999.9 сая төгрөгийн үнэ бүхийн Соёлын төвийн барилгыг бүртгэсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Дуусаагүй барилга дансанд өмнөх онд 8 байгууллагын 1,546.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэйгээс тайлант онд 1 байгууллагын 11.0 сая төгрөгийн дуусаагүй барилга нэмэгдэж, 2 байгууллага 30.0 сая төгрөгийн дуусаагүй барилгыг ашиглалтад хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж, оны эцэст 8 байгууллагын 1546.5 сая төгрөгийн хөрөнгө дуусаагүй үйлдвэрлэл дансанд үлдэгдлээр байна.

Энэ нь Биеийн тамир спортын газрын усан бассейн спорт цогцолборын барилгын суурийн хэсэг болох 809.9 сая, Баян-Овоо хуучин спорт заалны барилга 5.8 сая, Бууцагаан сумын бага сургуулийн барилгын суурь 316.8 сая, соёлын төвийн барилгын суурь болох 205.0 сая, Баянговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн цэвэр бохир усны шугам 10.0 сая, Заг сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ахмадын өргөө 198.1 сая төгрөг, Өлзийт сумд төсвийн хөрөнгөөр хийсэн 7.4 сая төгрөгийн тоглоом, Хүрээмарал сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн 7.4 сая төгрөгийн цэцэрлэгт хүрээлэн, Баянхонгор-Чандмань ХК-ийн 11.0 сая төгрөгийн зураг төсөв зэргийг дуусаагүй барилгад бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Дуусаагүй барилга дансанд 2012 оноос хойш улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж дутуу баригдсан цаашид дуусгах эсэх нь тодорхойгүй Бууцагаан сумын бага сургуулийн барилгын суурь 316.8 сая, соёлын төвийн барилгын суурь болох 205.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Иймд тус хөрөнгүүдийг цаашид хэрхэн ашиглах талаар санал боловсруулж арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийг ашиглах жилийг программд “-1”, “0”, “2019” гэх мэтээр буруу оруулснаас тайлант жилийн элэгдлийн зардал буруу илэрхийлэгдсэн, хүлээж авсан хөрөнгийг орлого авч бүртгээгүй, хөрөнгийн тооллого тооцоог хийгээгүй, үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн, эргэлтийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн зэрэг нийтлэг зөрчил илэрсэн байна.

Тухайлбал:

- Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэг, Жинст сумын ЗДТГ нь зарим хөрөнгийн ашиглах жилүүдийг программд оруулаагүйгээс элэгдэл бодогдоогүй;
- Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэг, Эрдэм ахлах сургууль, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, -Овоо сумын ЗДТГ, Хот тохижилт үйлчилгээний газар, Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төв, Сум дундын ойн анги, Тэмүжин театр, Шинэжинст, Эрдэнэцогт сумын ЗДТГ, Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль зэрэг нийт 21 байгууллага хөрөнгийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, тооллогын бүртгэлд хөрөнгө орхигдуулж тоолсон, хөрөнгийг орлого аваагүй, үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн;

Аудитын илрүүлэлт:

- Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдын ЗДТГ-ын хөрөнгөд тус бүр 920.0 сая төгрөгөөр бүртгэлтэй сэргээгдэх эрчим хүчний байгууламжуудын хөрөнгөөс зарим хэсэг нь ашиглалтгүй болсон, эвдэрсэн байхад анх хөрөнгийг бүртгэхдээ нэр төрлөөр нь үнэлж бүртгээгүйгээс эвдэрсэн хөрөнгүүд данс бүртгэлээс хасагдаагүй байгаа тул хөрөнгийг нэр төрлөөр нь зөв ангилж бүртгэн, ашиглалтгүй хөрөнгүүдийг холбогдох байгууллагын шийдвэрийг гаргуулж данснаас хасах зөвлөмжийг өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргад хүргүүлсэн ч хэрэгжээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

- Аймгийн ИТХ-ын 2021.06.29-ны өдрийн хуралдааны 3/12 дугаар "Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор 5,262.9 сая төгрөгийн 21 төрлийн ажлын хэрэгжүүлэхээр уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг 15 аж ахуйн нэгжтэй 9,150.0 сая төгрөгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулж 3,361.4 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн ч хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.,

Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, эрх бүхий эзэмшигчийг тогтоолгож хөрөнгөд бүртгэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.


3.5.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Баянхонгор аймгийн Засаг даргын 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт бүртгэгдээгүй байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 11,293.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 14,913.9 сая төгрөг болж, 3,620.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үүнээс богино хугацаат өр төлбөр 7,444.1 сая төгрөг болж өмнөх оноос 3,810.1 сая төгрөгөөр өссөн ба нийт өр төлбөрийн 49.9 хувийг богино хугацаат өр төлбөр, 50.1 хувийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна.



Хүснэгт № 17. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Ангилал	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), бууралт (-)	Хувь
Богино хугацаат өр төлбөр	3,634.1	7,444.1	3,810.1	49.9
Ажилчидтай холбогдсон өглөг	47.0	115.9	68.9	1.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	222.1	512.2	290.2	6.9
Байгууллагад өгөх өглөг	3,019.2	6,543.6	3,524.3	87.9
Хувь хүмүүст өгөх өглөг	99.9	6.5	(93.4)	0.1
Татварын өглөг /ТӨҮГ/	124.5	87.9	(36.5)	1.2
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/		0.1	0.1	0.0
Дансны өглөг /ТӨҮГ/	0.8	18.5	17.8	0.2
Урьдчилж олсон орлого	120.6	159.5	38.8	2.1
Урт хугацаат өр төлбөрийн дүн	7,659.3	7,469.5	(189.8)	50.1
Төгрөг	7,073.6	6,964.9	(108.6)	93.2
Хувь хүмүүсийн зээл	2,111.9	2,062.4	(49.5)	
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	4,961.7	4,902.6	(59.1)	
Гадаад валют	585.7	504.6	(81.2)	6.8
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	585.7	504.6	(81.2)	
Нийт өр төлбөрийн дүн	11,293.3	14,913.6	3,620.3	100.0
Үүнээс байгууллагын төрлөөр:				
Богино хугацаат өр төлбөр дүн	3,634.1	7,444.1	3,810.1	49.9
Төсөвт байгууллага	1,094.0	843.2	(250.8)	11.3
Төсөл/сан	2,156.9	6,285.2	4,128.2	84.4
ТӨҮГ болон ОНӨҮГ	383.1	315.7	(67.4)	4.2
Урт хугацаат өр төлбөрийн дүн	7,659.3	7,469.5	(189.8)	50.1
Төсөвт байгууллага	4,818.2	4,818.2	0.0	64.5
Төсөл/сан	-	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,841.1	2,651.3	(189.8)	35.5
Нийт өр төлбөрийн дүн	11,293.3	14,913.6	3,620.3	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх оны аудит хийсэн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 3,641.9 сая, урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 7,651.5 сая, төгрөгөөр тайлагнасан байхад 2021 оны санхүүгийн тайлангийн богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 3,634.1 сая, урт хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 7,659.3 сая төгрөгөөр буюу

богино хугацаат өр төлбөрийг 7.8 сая төгрөгөөр дутуу, урт хугацаат өр төлбөрийг 7.8 сая төгрөгөөр илүү бүртгэж тайланд өөрчлөлт оруулсан байна. Энэ талаар тодруулахад “Чандмань Баянхонгор” ХК-ийн арилжааны банкны зээлийн 51.3 сая төгрөгийн үлдэгдлийг 59.2 сая төгрөг болгон өөрчилсөн ба “Сангийн яамны Э-тайланд Засгийн газрын нэгтгэсэн тайлангаар өөрчлөлт оруулсан байна” гэсэн тайлбарыг аймгийн СТСХ-ийн ерөнхий нягтлан бодогч болон “Чандмань Баянхонгор” ХК-ийн нягтлан бодогч нар өгч байна.

Богино хугацаат өр төлбөр:

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн 11.3 хувь буюу 843.2 сая төгрөгийн өглөг нь төсөвт байгууллагын, 84.4 хувь буюу 6,285.2 сая төгрөг нь техник хяналт, барьцаа данс, нэмэлт санхүүжилтийн өглөг, 4.2 хувь буюу 315.7 сая төгрөг нь орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын өр төлбөр байна.

Техник хяналт, барьцаа дансны өглөгийн үлдэгдэл нь 2019-2021 онд ашиглалтад орсон барилга, байгууламжийн чанарын баталгааны барьцаа 908.2 сая, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 7 төсөл, арга хэмжээний дутуу санхүүжилт болох 4,990.5 сая, зохиогчийн хяналтын зардлын үлдэгдэл 88.1 сая, 2017 онд 7 аж ахуйн нэгжийн уул уурхайн нөхөн сэргээлтийн 61.3 сая төгрөгийн барьцаа нийт 6,048.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байхад санхүүгийн тайланд Баян-Өндөр сумын цэцэрлэг, Бөмбөгөр сумын соёлын төвийн барилгын өргөтгөл, их засварын барьцаа 38.4 сая төгрөгийн өглөгийг дутуу бүртгэснийг аудитын явцад залруулсан болно.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн Барьцаа хөрөнгийн данснаас 2021 онд “Мандал баян булаг” ХХК, “Их ган зүү” ХХК-д тус бүр 50.0 сая төгрөгийг Коронавируст халдварын эсрэг цогц тусламж үйлчилгээний хүрээнд Эрдэнэ мандал ахлах сургуулийн дотуур байранд 130 ор дэлгэж хэвтэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлсний урьдчилгаа санхүүжилтэд аймгийн онцгой комиссын 2021.09.04-ний өдрийн 61 дүгээр хуралдааны шийдвэрээр ЭМД-ийн сангаас санхүүжилт орж ирэхэд буцаан авахаар олгосон, техник хяналтын данснаас “Мед импекс интернэшнл” ХХК-д 30.0 сая төгрөгийн ковидын төстийн үнэ шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2 дахь “төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны “Захиалагчийн хяналтын зардлын нэр төрөл батлах тухай 85 дугаар тушаалаар баталсан зардлын ангиллыг тус тус зөрчсөн байна.

Иймд “Мандал баян булаг” ХХК, “Их ган зүү” ХХК-д олгосон 100.0 сая төгрөгийн ковидын санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд буцаан төвлөрүүлэх, техник хяналтын зардлаас зориулалт бусар зарцуулсан 30.0 сая төгрөгийн төстийн үнийг техник хяналтын дансанд буцаан төвлөрүүлж зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Баянхонгор аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат үнэт цаас, богино хугацаат зээл байхгүй ба оны эхэнд 2 ОНӨААН-тэй холбоотой 120.6 сая төгрөгийн урьдчилж орсон орлого бүртгэлтэй байснаас тайланд онд 38.8 сая төгрөгийн орлого нэмэгдэж оны эцэст 159.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Тайлант оны эдгээр урьдчилж орсон орлого нь “Баянхонгор эрчим хүч” ЦТХХК-ы 12.8 сая, цахилгааны 20.3 сая, бусад төлбөртэй үйлчилгээний 5.1 сая, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн төсөл хөтөлбөрт олгосон зээлээс суутгасан хяналтын зардал 124.1 сая, түрээслэгчдээс урьдчилж авсан нэг сарын түрээсийн төлбөр 9.9 сая төгрөгийн урьдчилж орсон орлого бүртгэгдсэн байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онуудад үүссэн олон жилийн насжилттай өглөгийг барагдуулдаггүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай батлагдсан маягтын дагуу тооцоо нийлж, баталгаажуулдаггүй, цалингийн санг нийгмийн даатгалын хэлтэст үнэн зөв мэдээлдэггүй, даатгуулагчийн кодыг зөрүүтэй мэдээлснээс өглөг үүссэн байхад залруулга хийдэггүй зэрэг нийтлэг зөрчил илэрсэн байна.

Тухайлбал:

Эрдэнэцогт, Баацагаан, Бөмбөгөр сумдын Эрүүл мэндийн төв, Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэг, Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр, Баянхонгор аймгийн сум дундын ойн анги зэрэг байгууллагууд санхүүгийн тайланд 256.3 сая төгрөгийн өглөгийг зөрүүтэй тусгасан байна.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа сумдын эрүүл мэндийн төвүүд нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг бүрэн аваагүйгээс нийт 519.0 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр үүссэн байна.

Иймд Цаашид Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн тооцоог тайлант хугацаанд нь бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөв.

Аймгийн Засаг дарга 2017.09.05-нд Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сантай “Санхүүгийн дамжуулах түрээсийн гэрээ” байгуулан нийт 80,170.8 ам.долларын буюу 200.0 сая төгрөгийн газар тариалангийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг жилийн 5.6%-ийн хүүтэй, 2 сарын хугацаатай төлбөрийг 2017.11.01-нд төлж дуусгах нөхцөлтэйгөөр зээлээр худалдан авч үүссэн ба төлбөр төлөгдөөгүй, гэрээний хугацаа дуусаж хугацаа хэтэрсэн байна.

Тус өглөгийг түрээслүүлэгч тал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай тооцоо нийлж баталгаажуулан төлбөрийг төлөх эсэх талаар шийдвэр гаргуулан өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргад хүргүүлсэн ч зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа тул албан шаардлага өгөв.

Урт хугацаат өр төлбөр:

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл оны эхэнд 7,659.3 сая төгрөг байсан ба тайлант онд 189.9 сая төгрөгийн өглөгийг барагдуулж оны эцэст 7,469.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 18. Урт хугацаат өр төлбөр /сая төгрөг/

Байгууллагын нэр	Зээлийн эх үүсвэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн гүйлгээний дүн	Хорогдсон гүйлгээний дүн	Эцсийн үлдэгдэл
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		7,659.3	-	189.9	7,469.5
Урт хугацаат зээл		7,659.3	-	189.9	7,469.5
Төгрөг		7,073.6	-	108.7	6,964.9
Чандмань Баянхонгор ХК	Чандмань Баянхонгор ХК Моп-1847	84.4			84.4
	Хас банкны зээл	59.2		59.2	-
Аймгийн ОНӨГ	Чандмань Баянхонгор ХК Моп-2301	4,818.2			4,818.2
"Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК	Төрийн сан /Орон нутгийн хөгжлийн сан/	1,557.4			1,557.4
	Төрийн сан /Орон нутгийн хөгжлийн сан/	429.5			429.5
	Төрийн сан /Ангилалдаагүй зардал-жимс жимсгэнэ тариалах/	50.0		49.5	0.5
	Төрийн сан /ЖДҮ-ийн эргэн төлөлт	75.0			75.0
Гадаад валют		585.7	0.0	81.2	504.6
"Баянхонгор - Эрчим хүч" ЦТХХК	"Баянхонгор -Эрчим хүч"ЦТХХК-Моп-1847	19.3	-	8.1	11.2
	"Баянхонгор -Эрчим хүч"ЦТХХК-Моп-3500	566.4		73.1	493.4

Гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн дүн 249.7 сая төгрөгөөр буурсан нь "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК нь Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй МОН-1847 зээлээс 4.0 сая төгрөгийг төлж 4.1 сая төгрөгийг богино хугацаат өр төлбөрөөр бүртгэн, Дэлхийн банкны санхүүжилтээр олгосон МОН-3500 зээлээс 36.4 сая төгрөгийг төлж 36.7 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрөөр бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 19. Урт хугацаат өр төлбөр /сая төгрөг

Баянхонгор аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

№	Байгууллага	2019 оны үлдэгдэл	2020 оны үлдэгдэл	Гэрээний огноо	Үндсэн төлбөр эхлэх хугацаа	Үндсэн төлбөр дуусах хугацаа	Хугацаа хэтэрсэн/үндсэн төлбөр/ хүү	Хугацаа хэтэрсэн/ хүү	Үлдэгдэл	
									Баталгаа жуулсан	Баталгаа жуулаагүй
1. Гадаад эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн дүн										
А. Азийн хөгжлийн банк										
1	Чандмань Баянхонгор ХК Моп-1847	84.4	84.4	2007.06.16	2012.05.30	2025.11.30	20.5	2.4		84.4
2	"Баянхонгор -Эрчим хүч"ЦТХХК-Моп-1847	19.3	11.2	2006.04.19	2012.05.30	2025.11.30			11.2	
3	Орон нутгийн өмчийн газар	4,818.2	4,818.2							4,818.2
	Дүн	4,921.9	4,913.8	0	0	0	20.5	2.4	11.2	4,902.6
Б. Дэлхийн банк										
1	"Баянхонгор -Эрчим хүч"ЦТХХК-Моп-3500	566.4	493.4	2006.11.27	2012.10.01	2036.10.01			493.4	
	Дүн	566.4	493.4						566.4	
	Нийт гадаад эх үүсвэрээс авсан зээлийн дүн	5,488.3	5,407.1						1059.76	4902.561
2. Дотоодын эх үүсвэрээс авсан зээлийн дүн										
Чандмань Баянхонгор ХК										
1	Хас банк	59.2	-	2018.05.17	2018.06.25	2023.05.25				
	"Баянхонгор үйлдвэржилт Хөгжлийн корпораци"ХХК	2,111.9	2,062.4	2,019.0	-	-	-	-	2,036.9	-
1	Төрийн сан /Орон нутгийн хөгжлийн сан/	1,557.4	1,557.4	2017.06.28					1,557.4	
2	Төрийн сан /Орон нутгийн хөгжлийн сан/	429.5	429.5	2018.04.20					429.5	
3	Төрийн сан /Ангилалдаагүй зардал-жимс жимсгэнэ тариалах/	50.0	0.5	2019					50.0	
4	Төрийн сан /ЖДҮ-ийн эргэн төлөлт	75.0	75.0							
	Нийт дотоодын эх үүсвэрээс авсан зээлийн дүн	2,171.1	2062.4				0.0	0	2036.9	0
	Нийт зээлийн дүн	7659.3	7469.5				0.0	0.0	3096.6	4902.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

- "Чандмань-Баянхонгор" ХК нь Азийн хөгжлийн банкны Моп-1847 төслийн зээлийн төлбөрөөс 2021 онд огт төлбөр төлөөгүй бөгөөд 20.5 сая төгрөгийн үндсэн зээл, 2.4 сая төгрөгийн зээлийн хүү нийт 22.9 сая төгрөгийн хуваарьт төлбөр төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн байна.

Иймд тус зээлийн хугацаа хэтэрсэн төлбөрийг төлж барагдуулан цаашид зээлийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлж байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Хот байгуулалтын салбарын МОН-2301 төсөлтэй холбоотой 4,818.2 сая төгрөгийн зээлийг аймгийн ОНӨГ-т 2019 онд шилжүүлэн бүртгэсэн ба тус зээлийн төлбөр төлөөгүй байна.

Харин өмнөх оны ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар дээрх урт хугацаат зээлтэй холбоотойгоор Хот байгуулалтын салбарын 2012-2014 оны хооронд хэрэгжсэн МОН-2301 төсөлтэй холбоотой "Чандмань Баянхонгор" ХК-аас аймгийн ОНӨГ-т шилжүүлэн бүртгэгдсэн 4,818.2 сая төгрөгийн урт хугацаат зээлийг хэрхэн барагдуулах, хөнгөлүүлэх талаар аймгийн ИТХ, Засгийн газарт хандан, арга хэмжээ авах асуудлыг тавьж шийдвэрлүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад өгсний дагуу аймгийн 2022 оны төсөвт 376.0 сая төгрөг төлөхөөр батлуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант онд "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-ийн урт хугацаат зээлийн дансанд бүртгэлтэй орон нутгийн санхүүжилтээс 49.5 сая төгрөгийг барагдуулсан ба харин төсөл хөтөлбөрт олгосон зээлээс суутгасан хяналтын зардал 124.1 сая, түрээслэгчдээс урьдчилж авсан нэг сарын түрээсийн төлбөр 9.9 сая нийт 134.0 сая төгрөгийн урьдчилж орсон орлогыг урт хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн байна.

Иймд урьдчилж орсон орлого 134.0 сая төгрөгийг аудитын явцад залруулж богино хугацаат өр төлбөрөөр бүртгэв.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 235,633.9 сая, эцсийн үлдэгдэл 275,872.1 сая төгрөг болж, өмнөх оноос 40,238.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 20. Хуримтлагдсан үр дүн /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	93,143.2	95,482.0	2,338.8	34.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	61,030.1	61,255.7	225.7	22.2
Хуримтлагдсан үр дүн	81,460.6	83,141.94	1,681.4	30.1
Тайлант үеийн үр дүн		35,992.4	35,992.4	13.0
Дүн	235,633.9	275,872.1	40,238.2	100.0
Үүнээс, байгууллагын төрлөөр			-	

Баянхонгор аймгийн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2021 оны Санхүүгийн Нэгтгэсэн Тайланд Хийсэн Аудитын Тайлан

Төсөвт байгууллага	200,201.50	238,062.6	37,861.1	86.3
Төсөл/ сан	843.30	1,099.6	256.3	0.4
Төрийн сан	3,610.60	5,395.6	1,785.0	2.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	30,978.50	31,314.4	335.9	11.4
Дүн	235,633.90	275,872.1	40,238.2	100

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

• Засгийн газрын оруулсан капитал данс нь үндсэн хөрөнгийн өсөлтийн 2,338.8 сая төгрөгөөр нэмэгдэж, дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгө бүртгэсэнтэй холбоотой 225.7 сая төгрөгөөр дахин үнэлгээний нөөц данс нэмэгдсэн ба тайлант үеийн үр дүн 36,122.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд Баянцагаан, Богд, Жаргалант сумдын Сум дундын эмнэлгүүдийг аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн тайланд тайлант онд нэгтгэсэнтэй холбоотой 1,283.5 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл, 637.9 сая төгрөгийн өмнөх үеийн үр дүн, 1,385.6 сая төгрөгийн Засгийн газрын оруулсан капитал данс тус тус нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

• Бодлогын өөрчлөлт алдааны залруулгын данс дахин үнэлгээний нэмэгдэлтэй хөрөнгө шилжиж ирсэн мөн акталсан, үндсэн хөрөнгийг үлдэгдэл залруулсан, өмнөх оны үндсэн хөрөнгийн элэгдэл, өглөг, авлагыг зөрүүтэй тооцсон зэргээр 1,681.4 сая төгрөгөөр өмнөх үеийн үр дүнг нэмэгдүүлсэн байна.

ТӨҮГ болон ОНӨҮГ хувьд эздийн өмч дансанд гарсан өөрчлөлт

Аймгийн Засаг даргын харьяаны орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот 7 байгууллагын санхүүгийн тайланд хуримтлагдсан үр дүн -1,497.4 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

Хүснэгт 21. ОНӨААН-ийн хуримтлагдсан үр дүн /сая төгрөг/

№	ААН нэр	тоо	Орлого	Зарлага	2020 оны үр дүн	Өмнөх үеийн үр дүн	Хуримтлагдсан үр дүн
1	Баянхонгор Эрчим хүч ХХК	1	11,264.5	11,680.3	(415.8)	(499.1)	(914.9)
2	Чандмань Баянхонгор ХК	1	2,195.1	2,133.1	61.9	358.3	378.7
3	Цэвэр хот ОНӨҮГ	1	740.1	690.7	49.3	(418.4)	(369.1)
4	Үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	1	105.5	351.8	(246.3)	(453.7)	(700.0)
5	Шинэжинст сумын тохижилт үйлчилгээний алба	1	196.8	120.7	76.0	(5.6)	70.5
6	Байшинтын таг ОНӨҮГ	1	427.7	417.4	10.3	-	10.3
7	Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	1	250.0	222.8	27.2	-	27.2
	ДҮН	7	15,179.6	15,616.9	(437.3)	(1,018.5)	(1,497.4)

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт санхүүжилтийн данс

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 3 байгууллага 110.8 сая, Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 10 байгууллага 157.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 118 байгууллага 4,258.9 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 50 байгууллага 2,566.3 сая, нийт 9,588.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 114 байгууллага 6,860.7 сая, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 1 байгууллага 3.8 сая, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардалд 2 байгууллага 152.0 сая, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгө тэтгэмжид 25 байгууллага 815.2 сая, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 58 байгууллага 1,128.7 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 3 байгууллага 117.2 сая, хөрөнгийн зардалд 3 байгууллага 15.6 сая нийт 9,093.1 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 495.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад нийт 1,128.7 сая төгрөг олгосныг байгууллагын төрлөөр нь авч үзвэл эрүүл мэндийн салбарын албан хаагчдад 377.6 сая, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчдад 550.9 сая, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын албан хаагчдад 200.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 156 мэдээллээс 108 мэдээллийг хугацаанд нь, 48 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хүснэгт 22. Шилэн дансны мэдээлэл

д/д	хугацаа	төрөл	удаа	хугацаанд нь мэдээлсэн	хугацаа хоцроосон	Хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	13	13	9	4	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан
2	Хагас жил	3	3	3	0	
3	Улирал бүр	2	8	7	1	Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
4	Сар бүр	5	60	37	23	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл 4,5,6,7,9,11 саруудад, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 9,12-р саруудад, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл 4,5,7,9,11 саруудад, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 3,4,5,6,7,9,11 саруудад, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг 1-9, 11 саруудад
5	Тухай бүр	6	72	52	20	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 6,9,10,11 саруудад, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг 1-9, 11 саруудад, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 5,7 саруудад, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт 5,8,9,12 саруудад
НИЙТ		28	155	91	59	

Эх сурвалж. Баянхонгор аймгийн шилэн дансны цахим хуудас

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2-т хамаарах орон нутгийн өмчит 179 төсөвт байгууллага, 3.1.3-т хамаарах орон нутгийн өмчит 5 аж ахуйн нэгж, 3.1.5-т хамаарах төсвөөс санхүүжилт авч байгаа 7 хувийн цэцэрлэг, 2 хувийн сургууль, 4 өрхийн эмнэлэг, ахмадын хороо, нийт 198 төсвийн байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн портал системд бүрэн хамрагдаж, мэдээллийг байршуулж иржээ.

3.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баянхонгор аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 135 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 6/22 дугаар тогтоолоор “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

Тус ТЕЗ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа, аудитор Ж.Өсөхбаяр, Б.Нарангэрэл, Н.Бүнчинсүрэн нар санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

3.9 Аудитын гол асуудал

ЭМС-ын 2019.11.29-ны өдрийн “Журам, шалгуур үзүүлэлт жагсаалт батлах тухай” А/540 дугаартай тушаалын дагуу Баянцагаан, Богд, Жаргалант сумдын Сум дундын эмнэлгүүдийг сумын Эрүүл мэндийн төв болгон статусыг өөрчлөн орон нутгийн төсвөөс санхүүжилт олгож аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байна.

Мөн Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 24 дүгээр тогтоолоор “Жаргалтай амьдрал, сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” ОНӨААТҮГ-ыг, Баян-Овоо сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр тогтоолоор “Байшинтын таг” ОНӨААТҮГ-ыг тус тус үүсгэн байгуулж санхүүгийн тайланг нэгтгэсэн бөгөөд Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд санхүүгийн тайлан, аудит хийлгэх хүсэлтээ ирүүлээгүй, аудитад хамрагдаагүй болно. “Байшинтын таг” ОНӨААТҮГ-ыг Баян-Овоо сумын ИТХ-ын хуралдааны 2022.04.07-ы өдрийн 01/06 дугаар тогтоолоор татан буулгасан байна.

3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 797.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 263.6 сая төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, 333.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгч, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 200.0 сая төгрөгийн 5 заалт бүхий зөвлөмжийг өгсөн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжилтийн хариуг 2021.08.26-ны өдрийн 7/1285 тоот албан бичгээр ирүүлснийг шалгахад биелэлт дараах байдалтай байна.

Хүснэгт:23 Өмнөх оны албан шаардлагын хэрэгжилт

№	Аудитаар өгсөн албан шаардлага	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	Аудитаар тооцсон биелэлт
1	Бөмбөгөр сумын спорт заалны барилгын ажлын санхүүжилтэд олгосон 333.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг мэргэжлийн байгууллага, хөрөнгийн үнэлгээнээр тогтоолгож дүгнэлт гаргуулах, тус ажлыг гэрээнд заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.	Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн 2021.06.21-ны өдрийн 7/916 тоот албан бичгээр ХОХБТ-т тус албан шаардлагын дагуу ажлыг зохин байгуулж, хэрэгжилтийг ирүүлэхээр хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна гэсэн тайлбарыг ирүүлсэн байна.	Хэрэгжээгүй. Биелэлт 0%
2	Цаашид санхүүгийн тайланд бүртгэлгүй малыг холбогдох стандартын дагуу үнэлж бүртгэх, бүртгэлтэй малын нас дэвшилтийн орлого, зарлага малын тоог “А” дансаар баталгаажуулж, тооллогын бүртгэлд хавсарган баталгаажуулж аудитын байгууллагад ирүүлэх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.	Аудитын дүгнэлтээр гарсан төсөвт байгууллагуудын малын тоог тухайн онд тоологдсон А дансыг үндэслэн орлогоор бүртгүүлж мөн сүргийн эргэлтийн тайланг авч 2021 оны эхний хагас жилийн тайлан тусгуулсан. Цаашид алдааг давтан гаргахгүй байхаар зөвлөмжийг хүргүүлсэн.	Аудитын дүгнэлтээр гарсан төсөвт байгууллагуудын малын тоог тухайн онд тоологдсон А дансыг үндэслэн орлогоор бүртгүүлж мөн сүргийн эргэлтийн тайланг авч 2021 оны эхний хагас жилийн тайлан тусгуулсан. Биелэлт 100%
3	Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн “Хот байгуулалтын салбарын 2012-2014 оны хооронд хэрэгжсэн МОН-2301 төсөлтэй холбоотой “Чандмань Баянхонгор”ХК-аас аймгийн ОНӨГ-т шилжүүлэн бүртгэгдсэн 4,818.2 сая төгрөгийн урт хугацаат зээлийг хэрхэн барагдуулах, хөнгөлүүлэх талаар аймгийн ИТХ, Засгийн газарт хандан, арга хэмжээ авхуулах асуудлыг тавих” гэсэн өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	Аймгийн ЗДТГ-ын 2021.12.03-ны өдрийн 7/1793 тоот бичгээр тус өглөгийг барагдуулах талаар аймгийн ИТХ-д санал хүргүүлсний дагуу аймгийн 2022 оны орон нутгийн төсөвт 376.0 сая төгрөгийн өглөгийг барагдуулахаар батлуулсан.	Аймгийн 2022 оны төсөвт 376.0 сая төгрөг төлөхөөр батлуулсан байна. Биелэлт 100%
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ			67.0%

Ирүүлсэн албан шаардлагын хэрэгжилтээс үзэхэд Бөмбөгөр сумын спорт заалны барилгын ажлын санхүүжилтэд олгосон 333.5 сая төгрөгийн зөрчил нь 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил бөгөөд тус онд зөрчлийг арилгах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн ба 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар үзэхэд тус зөвлөмж хэрэгжээгүй байсан учир зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлсэн байна. Гэвч 2021 онд дээрх зөрчил арилгах албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэн зөрчлийг арилгуулах талаар арга хэмжээг авч ажиллах.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацаанд гаргаж Төрийн аудитын байгууллагад 2021.06.21-ний өдрийн 7/918 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Аудитаар нийт 5 заалт бүхий 200.0 сая төгрөгийн зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг 100 хувь, 1 зөвлөмжийг 50 хувь, огт хэрэгжүүлээгүй 1 зөвлөмж, байгаа ба нийт зөвлөмжийн хэрэгжилт дунджаар 70 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт:24 Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт

№	Өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	Аудитаар тооцсон биелэлт
1	Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй "Сэргээгдэх эрчим хүч"-ний байгууламжийг нэр төрлөөр нь зөв ангилж бүртгэн, ашиглалтгүй хөрөнгүүдийг данснаас хасах шийдвэрийг холбогдох байгууллагаар гаргуулж данснаас хасах ажлыг зохион байгуулах.	Тус сумдын "Сэргээгдэх эрчим хүч"-ний байгууламжийг бөөн дүнгээр бүртгэсэн, хөрөнгийн нэр төрөл тус бүрээр тоо хэмжээг авч, ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгийг актуулах саналыг ОНӨГ-аарт ирүүлэхийг 2021.06.21-ний өдрийн 7/918 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд аймгийн ОНӨГ-аас 2021.07.07-ны өдрийн А/153 тоот албан бичгээр зөвлөмжийн хэрэгжилтийн хариуг ирүүлсэн байна. Тус хөрөнгийг нэр төрлөөр нь ангилан бүртгэсэн боловч ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгүүдийг данснаас ажил хийгдээгүй байна.	Тус сумдын "Сэргээгдэх эрчим хүч"-ний байгууламжийг бөөн дүнгээр бүртгэсэн, хөрөнгийн нэр төрөл тус бүрээр тоо хэмжээг авч, ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгийг актуулах саналыг ОНӨГ-аарт ирүүлэхийг 2021.06.21-ний өдрийн 7/918 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд аймгийн ОНӨГ-аас 2021.07.07-ны өдрийн А/153 тоот албан бичгээр зөвлөмжийн хэрэгжилтийн хариуг ирүүлсэн байна. Тус хөрөнгийг нэр төрлөөр нь ангилан бүртгэсэн боловч ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгүүдийг данснаас ажил хийгдээгүй байна. Биелэлт 50%
2	Төсөвт байгууллагуудын хөрөнгийн дахин үнэлгээ дансны үлдэгдлийг хөрөнгө тус бүрээр тулган баталгаажуулж, 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд зөрчлийг залруулж бүртгэх.	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү үүссэн 16 байгууллагын 5.7 тэр бум төгрөгийн хөрөнгийг залруулан бүртгэсэн. Мөн 6 байгууллага данс бүртгэлээс хасахдаа дахин үнэлгээний зөрүүг хасаагүй байсан улмаас үүссэн 907.1 сая төгрөгийн зөрүү үүссэнийг өмнөх оны үр дүнд хааж залрууллаа.	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү үүссэн 16 байгууллагын 5.7 тэр бум төгрөгийн хөрөнгийг залруулан бүртгэсэн. Мөн 6 байгууллага данс бүртгэлээс хасахдаа дахин үнэлгээний зөрүүг хасаагүй байсан улмаас үүссэн 907.1 сая төгрөгийн зөрүү үүссэнийг өмнөх оны үр дүнд хааж залруулсан байна. Биелэлт 100%
3	Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн Сум дундын ойн ангид бүртгэлтэй тус өглөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай тооцоо нийлж баталгаажуулан төлбөрийг төлөх эсэх талаар шийдвэр гаргуулан өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.	Аймгийн ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 200.0 сая төгрөгийн өртөг бүхий машин тоног төхөөрөмжийг шилжүүлэх, шилжүүлэн авах хүсэлтийг 2 байгууллагаас авсан бөгөөд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх тогтоолын төслийг хурлын ажлын албанд хүргүүлсэн байна.	Хэрэгжээгүй Биелэлт 0%
4	Цаашид оны эцэст төсвийн байгууллагын нэмэлт санхүүжилтийн буцаан төвлөрүүлсэн үлдэгдлийг авлага, өглөгөөр тусгах эсэх талаар шийдвэрийг дараа оны 01 дүгээр сарын 20-ны дотор гаргуулж тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, авлага, өглөгийг тухай бүр холбогдох байгууллагын санхүүгийн тайланд тусгаж байх.	Нийт төсөвт байгууллагуудад Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын байгууллагаас 2021 онд өгсөн зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлэн ажиллах чиглэл хүргүүлсэн.	Нэмэлт санхүүжилтийн журмын дагуу 2021 онд Нэмэлт санхүүжилтийн тайланг авч төвлөрүүлсэн орлогоос дараа жил зарцуулагдах үлдэгдлийг 2021 оны санхүүгийн тайланд авлагаар тусгуулж ажилласан байна Биелэлт 100%
5	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулж, түүнд тавих хяналтыг сайжруулах.	Шилэн дансны цахим хуудаст байршуулж буй мэдээллийг хуулийн хугацаа, үнэн, зөв байдалд хяналтыг сайжруулах зорилгоор Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын зүгээс Төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2021 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт шалгалт хийсэн тайланг 8 дугаар сарын 5-ны өдрийн 77 дугаар албан бичгээр ирүүлсэн байна. Хэлтсийн зүгээс удаа дараа хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллагаагүй байгууллага, нягтлан бодогчдод хариуцлага тооцох албан бичгийг хүргүүлээд байна. Шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулах сургалтыг шинэ нягтлан бодогчдыг хамруулан, бүсчлэн хоёр хувааж "ZOOM" онлайнаар хийхээр ажиллаж байна.	Өмнөх онуудад сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн дуусаагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгасан 211.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний авлагыг 2020 оны 1-р улирлын санхүүгийн тайланд залруулж бүртгэсэн байна. Биелэлт 100%
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ			70%

3.11 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.


Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 161 төсвийн байгууллага, 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 өрхийн эрүүл мэндийн төв, 42 тусгай сан, 20 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нийт 234 байгууллагын санхүүгийн тайлан болон ангилагдаагүй зардал, замын сан, хяналтын барьцаа данс, засаг даргын нөөц хөрөнгийн данс нийт 5 дансны гүйлгээ нэгтгэгдсэнээс 232 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулж 141 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 91 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 24 дүгээр тогтоолоор “Жаргалтай амьдрал, сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” ОНӨААТҮГ-ыг, Баян-Овоо сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр тогтоолоор “Байшинтын таг” ОНӨААТҮГ-ыг тус тус үүсгэн байгуулж санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 91 байгууллагыг түүвэрт хамруулж, 142 байгууллагад дүгнэлт хүргүүлснээс 119 байгууллагад “Зөрчилгүй”, 21 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” дүгнэлт өгсөн байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын харьяаны төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 12,415.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,083.1 сая төгрөгийн 87 алдааг санхүүгийн тайланд залруулж, 381.6 сая төгрөгийн зөрчилд 102 төлбөрийн акт тогтоож, 2,391.4 сая төгрөгийн зөрчилд 89 албан шаардлага хүргүүлж, 8,559.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 399 зөвлөмжийг менежментийн захидлаар хүргүүлсэн.

Нийт алдаа, зөрчлийн 32.5 хувь буюу 4,030.2 сая төгрөг нь санхүүгийн тайлагналын алдаа зөрчил байгаа бол 67.5 хувь буюу 8,385.6 сая төгрөгийн алдаа, зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын алдаа, зөрчил байна.



Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчлийг өмнөх онтой харьцуулбал санхүүгийн тайланд залруулсан алдаа 1,179.8 сая төгрөгөөр буурч, залруулагдаагүй алдаа 5,931.2 сая төгрөгөөр нэмэгдсэнээс төлбөрийн актын дүн 139.9 сая төгрөгөөр буурсан ч, албан шаардлага 955.2 сая, зөвлөмж 5,127.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 25. Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл /сая.төг/

Он	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Залруулагдаагүй алдааны дүн	Санхүүгийн тайланд залруулсан алдааны дүн	Нийт алдааны дүн
2020	521.5	1,436.2	3,431.9	5,389.6	2,262.9	7,652.5
2021	381.6	2,391.4	8,559.7	11,332.7	1,083.1	12,415.8
Өөрчлөлт	(139.9)	955.2	5,127.8	5,943.1	(1,179.8)	4,763.3

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагын нийт зөрчлийг өмнөх онтой харьцуулахад алдаа зөрчлийн дүн өмнөх оноос 4,751.4 сая төгрөгөөр нэмэгдсэн зөрчилтэй саналт, дүгнэлт авсан байгууллагын тоо өмнөх оноос буурахгүй байгаа нь дараах зүйлсээс шалтгаалсан байна. Үүнд:

1. Аймаг, сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар анхан шатны баримтын бүрдүүлэлт, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах гүйлгээнд тавих хяналт хангалтгүй, төсвийн хуваарьт өөрчлөлт орж, шинэчлэгдсэн хуваарь батлагдаагүй байхад мөн төсвийн захирагч, нягтлан бодогч нарын гарын үсэг зурагдаагүй байхад зарим гүйлгээг хийдэг;
2. Эд харцуцагч бараа материалын тайланг батлагдсан маягтын дагуу анхан шатны баримтад үндэслэн сар бүр гаргаагүй байхад нягтлан бодогч нарын тавих хяналт тавиаагүй;
3. Сангийн сайдын 2014 оны 55, 2021 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-ын дагуу зарлагын гүйлгээг бүрэн хянаагүй;
4. Цалингийн санг нийгмийн даатгалын хэлтэст үнэн зөв мэдээлдээгүй, даатгуулагчийн кодыг зөрүүтэй мэдээлснээс авлага, өглөг үүссэн байхад залруулга хийдээгүй;

5. Эд хөрөнгийн тооллогын комисст эд хариуцагч, нягтлан бодогчийг оруулсан. Мөн бараа материалыг тоолдоггүй, тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж даргын тушаалаар баталгаажуулдаггүй;
6. Эргэлтийн хөрөнгийг акталж данснаас хасахдаа даргын тушаал гаргаагүй, мөн устгал хийсэн акт үйлдээгүй;
7. Үндсэн хөрөнгийг ашиглах жилийг программд буруу оруулснаас тайлант жилийн элэгдлийн зардлыг буруу тайлагнасан;
8. Хэмнэгдсэн зардлыг оны эцэст эд хогшил худалдан авах зардалд нэмж зохицуулалт хийж, шууд гэрээ байгуулсан аж ахуйн нэгж байгууллагаас хөрөнгийг хүлээн аваагүй байхад мөнгийг шилжүүлсэн;
9. Байгууллагын дарга нар ээлжийн амралтыг биеэр эдлээгүй гэсэн шалтгаанаар амралтын нөхөн олговор, цалинг давхардуулан авсан;
10. Байгууллагын дарга нар тушаал гаргаж өөртөө хоол, унааны мөнгө, түлшний хөнгөлөлт авсан;
11. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт байгууллагын дарга хяналтыг тухай бүр хийж баталгаажуулдаггүй, нягтлан бодогч нар өөрсдөө хийж баталгаажуулж байгаагаас хяналт суларч байршуулбал зохих мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь байршуулдаггүй;

Иймд дээрх зөрчлүүд арилгахгүй давтан гарч байгаа нь байгууллагын удирдлага, төсвийн шууд захирагч нарын ажлын хариуцлага, төсвийн тухай хуулийн талаарх мэдлэг, сахилга бат хангалтгүйтэй шууд холбоотой байгаа тул үүнийг онцгой анхаарч төсөвт байгууллагын удирдлагуудын төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар:

Харьяа төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар захирагчийн байгууллагаас 20 байгууллагад “Зөрчилгүй”, Бууцагаан, Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Хүснэгт 26. “Хязгаарлалттай”, “Сөрөг” санал дүгнэлт авсан төсвийн төвлөрүүлэн захирагч

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
"ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"	
БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГА	- Тайлант онд ОНХС-гийн хөрөнгөөр өвс авахаар Навка ХХК-тай гэрээ байгуулж 21,000.0 мянган төгрөгийг шилжүүлэн 10,000.0 мянган төгрөгийн худалдан авалт хийж түүнээс үүссэн хоорондын тооцооны авлага 11,000.0 мянга, иргэдэд зээлээр өгсөн өвсний үнэ 9,400.0 мянган төгрөгийн авлагыг тус тус санхүүгийн тайланд тусгаагүй. - Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд 134,996.5 мянган төгрөгийн сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага байгаагаас 55,260.6 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрснийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА	Сум хөгжүүлэх сангийн 197.8 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдлийг зээлдэгч нэг бүрээр баталгаажуулаагүй, сангийн тайланг зөрүүтэй бэлтгэсэн байхад Санхүүгийн алба хяналт хийлгүй Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгасан.

Эх сурвалж: Төсвийн төвлөрүүлэн захирагч нарын аудитын тайлан, аудитын гэрчилгээ

Аудитаар нийт 1,067.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 247.5 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 79.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 197.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 542.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 78 зөвлөмж өглөө.

ТТЗ-ийн санхүүгийн тайланд илэрсэн нийтлэг зөрчил нь дээд шатны төсвийн захирагч төсөвт зохицуулалт хийж сумд олгох тусламж санхүүжилтийн орлогыг өөрчилсөн байхад сумын ИТХ-д өргөн барьж төсөвт тодотгол хийгээгүй, сумдын орон нутгийн орлогын гүйцэтгэлийн аймгийн Татварын хэлтэст үнэн зөв мэдээлээгүй, Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг буруу оруулсантай холбоотой тул цаашид сумдын санхүүгийн албаны дарга нарын ажлын хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

Төсвийн шууд захирагчийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

Харьяа төсвийн байгууллагаас 87 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 116 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгснөөс 99 байгууллагад “Зөрчилгүй”, 17 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 10,329.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 793.8 сая төгрөгийн 79 алдааг залруулж, 196.5 сая төгрөгийн зөрчилд 93 төлбөрийн акт тогтоож, 1,661.2 сая төгрөгийн зөрчилд 84 албан шаардлага хүргүүлж, 7,667.8 сая төгрөгийн зөрчилд 306 зөвлөмж өглөө.

Хүснэгт 27. "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан төсвийн шууд захирагч

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
"ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"	
БАЯНХОНГОР СУМЫН ЭРДЭМ СУРГУУЛЬ	Бараа материалд орлогоор сонины үнэ, хогны төлбөр, санхүүгийн программын лицензийн төлбөр зэрэг шууд зардал бүртгэсэн, төсвийн захирагчийн шийдвэргүйгээр 3,605.8 мянган төгрөгийн эм боох материалыг акталсан, тайлант онд бэлтгэсэн бараа материалыг нэр төрлөөр нь бүртгээгүй, өмнөх жилийн аудитаар байгууллагын жилийн эцсийн тооллого, тооцоог бодитой, чанартай гүйцэтгэх, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хариуцлагыг дээшлүүлэх зөвлөмжийг өгсөн байхад зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.
БАЯНХОНГОР СУМЫН 14 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүн гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлаас хэтэрсэн, нярав бараа материалын тайланг зохих стандартын дагуу гаргаагүй байхад дарга, нягтлан бодогч нар хяналт тавиагүй, цалингийн зардлын хэмнэлтийг урсгал засварын үйл ажиллагаанд зарцуулсан, өмнөх оны аудитаар Төсвийн тухай хуулийг мөрдөж, батлагдсан орон тоонд багтаан ажиллах зөвлөмжийг өгсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй 2021 онд батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласан.
БАЯНХОНГОР СУМЫН 11 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй худалдан авсан хүнсний тайланг нярав тайлан гаргасан байхад Нягтлан бодогч нь санхүүгийн программд бараа материалыг бүртгээгүй, мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардал бүртгэсэн байна. Санхүүгийн тайлан, няравын тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.
БАЯНХОНГОР СУМЫН 13 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ	Аймгийн Онцгой комиссоос хоол бэлтгүүлэхээр олгосон 23,364.5 мянган төгрөгийг хүнсний материалын орлого, зарлагыг санхүүгийн тайланд тусгаж тайлагнаагүй байна. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед байгууллагын төсвөөс нэмж 14,116.3 мянган төгрөгийг нэг удаагийн аяга, таваг халбага уут зэргийг худалдан авч зарцуулахдаа Төсвийн захирагч шийдвэр гаргаагүй.
БАЯНХОНГОР СУМЫН 2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ	оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас төлөх төлбөрийн актыг төсвөөс төлсөн. Засгийн газрын 2021 оны 43 дугаар батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар арга хэмжээний тухай" тогтоолыг баримталж ажиллалгүй албан хаагчдын үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон, хүнсний материал нөөцөлж төсөвт төвлөрүүлээгүй байна.
ЖИНСТ СУМЫН ЗДТГ	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүн гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлаас хэтэрсэн, байгууллагын даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс хөрөнгийг бүрэн тоолоогүй, тооллогын дүнд үндэслэн нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй, байгууллагын 2020 оны санхүүгийн тайлангийн аудит, 2021 оны завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс зөрчил давтагдан гарсан.
ШИНЭЖИНСТ СУМЫН ЗДТГ	Сумын ЗДТГ-ын 2021.12.14-ний өдрийн А/32 дугаар тушаалаар жилийн эцсийн тооллого явуулах ажлын хэсэг томилогдож эд хөрөнгийг тоолсон ба тооллогын комисс нь тооллого хийсэн тухай тэмдэглэл үйлдэж өмч хамгаалах зөвлөлд хүргүүлээгүй, нягтлан бодогч тооцоог бодож тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗДТГ	Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 31,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий хог тээврийн машин нь байгууллагын нэр дээр бүртгэлгүй, хувь хүний нэр дээр бүртгэгдсэн зөрчлийг арилгах албан шаардлагыг өгсөн байхад 2 жилийн хугацаанд зөрчлийг арилгаагүй.
БАЯНХОНГОР АЙМГИЙН СУМ ДУНДЫН ОЙН АНГИ	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүн гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлаас хэтэрсэн, "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-тай холбоотой 73,699.5 мянган төгрөгийн авлага, 200,000.0 мянган төгрөгийн өглөгийг тайлант онд барагдуулаагүй байхад зардалд бичиж хаасан, санхүүгийн тайланд бүртгэлтэй 48,782.6 мянган төгрөгийн бараа материалыг актлахдаа устгал хийсэн акт үйлдээгүй, бойжуулалтын талбайд суулгасан 16,880.0 мянган төгрөгийн 4,600 ширхэг модыг зарлагадаж тайлант жилийн зардлаар бүртгэсэн.
БОГД СУМЫН ЗДТГ	Орон нутгийн өмчийн 2019 оны үзлэг тооллогоор 41,500.0 мянган төгрөгийн хөрөнгө дутагдуулсныг өмнөх оны санхүүгийн аудитаар хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх албан шаардлага өгч, аймгийн Цагдаагийн газрын эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх тасагт хүрүүлсэн гэх боловч өнөөг хүртэл хохирол барагдаагүй байна.
БАЯНЦАГААН СУМЫН ЗДТГ	Тайлант онд шилжиж ирсэн 25.0 сая төгрөгийн үнэ бүхий Лексус-470 маркийн автомашин нь банк бус санхүүгийн байгууллагын нэр дээр эзэмшлийн гэрчилгээтэй байгаа тус автомашинд 7,000.0 мянган төгрөгийн засвар хийсэн.

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
	Өмнөх оны аудитаар өгсөн “3 жил болоогүй TLC 200 автомашин засвар үйлчилгээ, зогсоолын төлбөр 8,149.9 мянган төгрөгийг төсвөөс гаргасанд төсөвт буцаан төлүүлж төсөвт учирсан хохирлыг арилгах” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗДТГ	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн авлагыг барагдуулах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргаж, үр дүнг тооцоогүй.
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР	- Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг мөнгөн гүйлгээ, үр дүнгийн тайланд зарцуулснаар тайлагнаж, нэмэлт санхүүжилтийн данс руу төвлөрүүлэн авлагаар тусгасан. - Байгууллагын үндсэн дансаар хийгдсэн гүйлгээг бүртгээгүй орхигдуулсан, Тайлант хугацааны 182,031.3 мянган төгрөгийн 48 гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардалд бичсэн. - Нягтлан бодогч байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллогын тооцоо бодсон актыг үйлдээгүй, тооллогын дүнг баталгаажуулаагүй. - Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгүүдийг бараа материалд бүртгэсэн. - Эмийн зардлаас худалдан авсан 2420.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг санхүүгийн орлого, зардлаар бүртгээгүй шууд зардлаар тайлагнасан.
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ	- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн авлагыг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй. -Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг журмын дагуу хийгээгүй, тооллогын дүнг баталгаажуулаагүй.
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЗДТГ	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн “Орон нутгийн өмчийн 2019 оны үзлэг тооллогоор дутагдсан 57600.0 мянган төгрөгийн хөрөнгийн эзэн холбогчийг тогтоож хуулийн байгууллагаар эцсийн шийдвэр гаргуулан байгууллагыг хохиролгүй болгох тухай Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 тоот захирамжийг төсвийн шууд захирагч хэрэгжүүлж ажиллаагүй байна” гэсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.
БУУЦАГААН СУМЫН ЗДТГ	-Санхүүгийн тайлангийн бараа материалын дансанд бүртгэлтэй 20,611.8 мянган төгрөгийн өвс тэжээлийн үнийг байгууллагын даргын шийдвэргүйгээр бараа материалын данснаас хассан байна. -Тайлант онд түлш, халаалтын 491.5 мянга, тээвэр шатахууны өглөг 1,351.9 мянга, үзэсгэлэнт Баянхонгор төслийн хүрээнд хийгдсэн видео контент, бичлэгийн ажлын хөлс 507.6 мянга, нийт 2,350.9 мянган төгрөгийн өр үүсгэн төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулсан.
БАЯНХОНГОР ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР	Тайлант онд бэлтгэн нийлүүлэгч нь тодорхойгүй 116,163.7 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авсан, өөрсдөө үйлдвэрлэсэн 88,845.2 мянган төгрөгийн эко хавтан, явган зам, замын хашлага зэргийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгээгүй. Мөн төсөвт 6 байгууллагуудад жагсаалтаар олгосон 39,808.9 мянган төгрөгийн өртөг бүхий эко хавтан, замын хашлага, явган замын талаар хяналт тавьж хөрөнгийг бүртгэлд тусгуулаагүй, тус байгууллагуудтай хоорондын тооцоог хийгээгүй.

Эх сурвалж: Төсвийн шууд захирагч нарын аудитын тайлан, аудитын гэрчилгээ

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар:

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн өмчит 7 аж ахуйн нэгж, 4 өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан нэгтгэгдэж байна.

Аймгийн Засаг даргын харьяа 4 өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, орон нутгийн өмчит 5 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгснөөс “Зөрчилгүй” 2, “Хязгаарлалттай” 2, “Сөрөг” 1 дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 1,010.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 41.6 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 97.4 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 532.4 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 339.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 15 зөвлөмж өгсөн.

Хүснэгт 28. "Хязгаарлалттай", "Сөрөг" санал дүгнэлт авсан орон нутгийн өмчит аж ахуйн нэгж

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
"ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"	
"ЦЭВЭР ХОТ" ОНӨААТҮГ	<p>-Нярвын тайлангаар бараа материалын сэлбэг хэрэгслийн орлогыг 34,929.9 мянга, зарлагыг 30,111.0 мянган төгрөгөөр бүртгэсэн байхад нягтлан бодогч нь санхүүгийн тайланд сэлбэг хэрэгсэл дансны орлогыг 9,711.6 мянга, зарлагыг 11,534.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна</p> <p>-Нягтлан бодогч нь анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгасан, нярав кассын тайлан гаргаагүй, бараа материалын тайланг холбогдох журам, стандартын дагуу бэлтгэж гаргаагүй, анхан шатны баримтыг санхүүгийн баримтад бүрэн хавсаргаагүй.</p> <p>-Урд оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн акт 2,630.0 мянган төгрөгийг барагдуулахдаа байгууллагын төсвөөс төлсөн.</p>
БАЯНХОНГОР ҮЙЛДВЭРЖИЛТ ХӨГЖЛИЙН КОРПОРАЦИ	<p>- Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүн гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлаас хэтэрсэн,</p> <p>- Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээлийг хугацаанд нь бүрэн төлүүлэх арга хэмжээ аваагүй,</p> <p>- Нярав бараа материалын тайланг бэлтгээгүй байхад нягтлан бодогч нягтлан бодох бүртгэлд тусгасан,</p> <p>- Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулаагүй, аудитаар өгсөн шилэн дансны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зээлийн эргэн төлөлтийн орлого болон захирлын хөрөнгө захиран зарцуулах тухай тушаалуудыг байршуулаагүй,</p> <p>- Өмнөх оны авлага, өглөгийг барагдуулж ажиллаагүй.</p>
"СӨРӨГ САНАЛ ДҮГНЭЛТ"	
ШИНЭЖИНСТ СУМЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА	<p>-Тус байгууллагын дансанд уул уурхайн компаниас гэрээний төлбөр (ямар гэрээ нь тодорхойгүй, нотлох баримтгүй) нэрээр 162,7 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж сумын Засаг даргын захирамжаар 132.7 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>-Нярвын бараа материалын тайланг санхүүгийн программын орлого, зарлагатай тулган шалгахад түлш, шатах тослох материалын тайлан 1.4 сая аж ахуй материалын тайлан 0.6 сая, Сэлбэг хэрэгслийн материалын тайлан 0.5 сая нийт 2.4 сая төгрөгөөр нягтлан бодогчийн санхүүгийн тайланд нярвын тайлангаас илүү орлого авч зарлага гаргасан.</p>

3.12 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.04.01-ний өдрийн 48 дугаар тогтоолоор "Баянхонгор-Тохижилт үйлчилгээ" төсөвт үйлдвэрийн газрыг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болгон хэлбэрийг өөрчилж, дүрмийг баталсан ч тайлант онд тус байгууллагад орон нутгийн төсвөөс 906.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байгаа нь өмнөх онд олгосон санхүүжилтээс 365.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байгаа тул дараагийн аудитаар төсвийн хөрөнгийн зарцуулалтыг авч үзэх.

2. Аймгийн ТЕЗ-ийн харьяа сумдын эрүүл мэндийн төвүүдэд Эрүүл мэндийн даатгалын сангаас 3,574.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүйг авлагаар бүртгэсэн ба тус авлагатай холбоотой 519.0 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр үүссэн байна. Тус санхүүжилтийг авлагыг бүрэн авч өглөгийг барагдуулан үлдэгдэл орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

3. Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2020.12.04-ны өдрийн "Аймгийн хөгжлийн төлөвлөгөө батлах тухай" 2/8 тогтоолоор аймгийн хөгжлийн төлөвлөгөөг баталсан байна. Аймгийн ИТХ-ын 2021.06.29-ны өдрийн хуралдааны 3/12 дугаар "Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор 5,262.9 сая төгрөгийн 21 төрлийн ажлын хэрэгжүүлэхээр баталсан байна.

Тайлант онд Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай" гэрээний загварын 2.1.3 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг үндэслэн "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх,

ажлын байр нэмэгдүүлэх тухай” гэрээг тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй харилцан тохиролцож уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг 15 аж ахуйн нэгжтэй 9,150.0 сая төгрөгийн орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.

Тайланд онд 15 аж ахуйн нэгжээс 3,361.4 сая төгрөгийн хандив авахаар аймгийн ИТХ-ын 2021.06.29-ны өдрийн хуралдааны 3/12 дугаар “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоолын дагуу зарцуулахдаа тухайн хандивлагч аж ахуйн нэгжээс гүйцэтгэгч компани руу шилжүүлэн хөрөнгө оруулалтын ажлыг хийж ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлын эзэмшигч тогтоох хүсэлтийн ХОХБТХ аймгийн ОНӨГ-т хүргүүлээгүйгээс хөрөнгө оруулалтаар хийсэн төсөл арга хэмжээ, бий болсон үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

Иймд төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар холбогдох хөрөнгө оруулалтын санхүүжилтийг, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, хэрэгжилтийг “Баянхонгор аймгийн орон нутгийн орлогод байгаль орчноос орж ирж байгаа хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт үр дүн 2020-2021” гүйцэтгэлийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 507.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 344.9 сая төгрөгийн 6 алдааг санхүүгийн тайланд залруулж 162.9 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүлж байна.

4.1 Залруулсан алдаа

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд Богд сумын ЗДТГ-ын 9.0 сая төгрөгийн үнэ бүхий худаг, 8.0 сая төгрөгийн үнэ бүхий үерийн даланг зам гүүрний байгууламж дансанд нэгтгэснийг санхүүгийн тайланд залруулсан.
- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд Баянхонгор сумын ИТХ-ын тайлант онд суутгасан 6.4 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг үлдэгдлээр нэгтгэснийг залруулсан.
- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд Баян-Өндөр сумын цэцэрлэг, Бөмбөгөр сумын соёлын төвийн барилгын өргөтгөл, их засварын барьцаа 38.4 сая төгрөгийн өглөгийг дутуу бүртгэснийг залруулсан.
- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн төсөл хөтөлбөрт олгосон зээлээс суутгасан хяналтын зардал 124.1 сая, түрээслэгчдээс урьдчилж авсан нэг сарын түрээсийн төлбөр 9.9 сая нийт 134.0 сая төгрөгийн урьдчилж орсон орлогыг урт хугацаат өр төлбөрөөр бүртгэснийг урьдчилж орсон орлогоор бүртгэж залруулав.
- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зураг төсвийн авлагын үлдэгдлийг 31.8 сая төгрөгөөр дутуу бүртгэснийг залруулав.
- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд төсөвт байгууллагуудад олгох нэмэлт санхүүжилтийн 237.0 сая төгрөгийн өглөгөөс 119.7 сая төгрөгийн өглөгийг тусгаж 117.3 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг өглөгөөр тусгаж залруулав.

4.3 Албан шаардлага

1. Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдын ЗДТГ-ын хөрөнгөд тус бүр 920.0 сая төгрөгөөр бүртгэлтэй сэргээгдэх эрчим хүчний байгууламжуудын хөрөнгөөс зарим хэсэг нь

ашиглалтгүй болсон, эвдэрсэн байхад анх хөрөнгийг бүртгэхдээ нэр төрлөөр нь үнэлж бүртгээгүйгээс эвдэрсэн хөрөнгүүд данс бүртгэлээс хасагдаагүй байгаа тул хөрөнгийг нэр төрлөөр нь зөв ангилж бүртгэн, ашиглалтгүй хөрөнгүүдийг холбогдох байгууллагын шийдвэрийг гаргуулж данснаас хасах зөвлөмжийг өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргад хүргүүлсэн ч хэрэгжээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалт санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10 дахь заалтын дагуу Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдын ЗДТГ-ын хөрөнгөд бүртгэлтэй сэргээгдэх эрчим хүчний байгууламжуудыг хөрөнгийн нэр төрлөөр нь зөв ангилж бүртгэн, ашиглалтгүй хөрөнгүүдийг холбогдох байгууллагын шийдвэрийг гаргуулж данснаас хасах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн “Сум дундын ойн ангид бүртгэлтэй Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих санд төлөх 200.0 сая төгрөгийн өглөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай тооцоо нийлж баталгаажуулан төлбөрийг төлөх эсэх талаар шийдвэр гаргуулан өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалт санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10 дахь заалтын дагуу Тариалан эрхлэлтийг дэмжих санд төлөх 200.0 сая төгрөгийн өглөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай тооцоо нийлж баталгаажуулан зээлийг хэрхэн барагдуулах, хөнгөлүүлэх талаар аймгийн ИТХ, Засгийн газарт хандан, арга хэмжээ авхуулах асуудлыг тавьж шийдвэрлүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

3. Баянхонгор аймгийн Барьцаа хөрөнгийн данснаас 2021 онд “Мандал баян булаг” ХХК, “Их ган зүү” ХХК-д тус бүр 50.0 сая төгрөгийг Коронавируст халдварын эсрэг цогц тусламж үйлчилгээний хүрээнд Эрдэнэ мандал ахлах сургуулийн дотуур байранд 130 ор дэлгэж хэвтэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлсний урьдчилгаа санхүүжилтэд аймгийн онцгой комиссын 2021.09.04-ний өдрийн 61 дүгээр хуралдааны шийдвэрээр ЭМД-ийн сангаас санхүүжилт орж ирэхэд буцаан авахаар олгосон, техник хяналтын данснаас “Мед импекс интернэшнл” ХХК-д 30.0 сая төгрөгийн ковидын төстийн үнэ шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2 дахь “төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны “Захиалагчийн хяналтын зардлын нэр төрөл батлах тухай 85 дугаар тушаалаар баталсан зардлын ангиллыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс 2 хувийн эмнэлэгт ковидын цар тахал өвчлөлийн үед ажиллуулсан урьдчилж олгосон 100.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд буцаан төвлөрүүлэх, техник хяналтын зардлаас зориулалт бусар зарцуулсан 30.0 сая төгрөгийн төстийн үнийг техник хяналтын дансанд буцаан төвлөрүүлж зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

4. Аймгийн ОНХС-аас 2018 онд аймгийн Түүх угсаатны зүйн музейн барилгын зураг төсвийн үнэд “Лайнконстракшн” ХХК -д 10.0 сая олгосон ч авлагын дэлгэрэнгүй бүртгэлээр 20.0 сая төгрөгөөр буюу 10.0 сая төгрөгөөр илүү бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү бүртгэсэн 10.0 сая төгрөгийн зөрчлийг холбогдох нотлох баримтыг үндэслэн залруулж зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргад хүргүүлэв.

5. “Чандмань-Баянхонгор” ХК нь Азийн хөгжлийн банкны Мон-1847 төслийн зээлийн төлбөрөөс 2021 онд огт төлбөр төлөөгүй бөгөөд 20.5 сая төгрөгийн үндсэн зээл, 2.4 сая төгрөгийн зээлийн хүү нийт 22.9 сая төгрөгийн хуваарьт төлбөр төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Иймд тус зээлийн хугацаа хэтэрсэн төлбөрийг төлж барагдуулан цаашид зээлийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлж байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

4.3 Зөвлөмж

1. Аймгийн ТЕЗ-ийн харьяа сумдын эрүүл мэндийн төвүүд нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг бүрэн аваагүйгээс 3,574.8 сая төгрөгийн санхүүжилтийн авлага, 519.0 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр үүссэн байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалт санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн тооцоог тайлант хугацаанд нь бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллан, цаашид өвчлөлтэй холбоотой үүссэн ЭМД-ын сангаас олгох санхүүжилтийг тухай бүр нь эсхүл улиралд нь бүрэн олгуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаж байх.

2. Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 24 дүгээр тогтоолоор “Жаргалтай амьдрал, сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” ОНӨААТҮГ-ыг, Баян-Овоо сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр тогтоолоор “Байшинтын таг” ОНӨААТҮГ-ыг тус тус үүсгэн байгуулж санхүүгийн тайланг нэгтгэсэн ч тус 2 аж ахуйн нэгж нь 2021 санхүүгийн тайлан, аудит хийлгэх хүсэлтээ ирүүлээгүй, аудитад хамрагдаагүй, Шинэжинст сумын Хот тохижилт үйлчилгээний алба нь уул уурхайн компаниас гэрээний төлбөр (ямар гэрээ нь тодорхойгүй, нотлох баримтагүй) нэрээр 162.7 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж сумын Засаг даргын захирамжаар 132.7 сая төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”, 25 дугаар зүйлийн 25.2 дахь “ Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудит хийгдээгүй 2 аж ахуйн нэгж болон Шинэжинст сумын Хот тохижилт үйлчилгээний албаны үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт аудитын албаар дотоод аудит хийлгэж үр дүнг тооцож ажиллах.

3. Дуусаагүй барилга дансанд 2012 оноос хойш улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж дутуу баригдсан цаашид дуусгах эсэх нь тодорхойгүй Бууцагаан сумын бага сургуулийн барилгын суурь 316.8 сая, соёлын төвийн барилгын суурь болох 205.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь “төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тус хөрөнгүүдийг цаашид хэрхэн ашиглах талаар санал боловсруулж арга хэмжээ авч ажиллах.

4. Тайлант онд “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК -ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021.01.29-ний өдрийн ““Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК -ийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” 02 дугаар тогтоолоор баталсан “Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төлөвлөгөө”-ний 3.3-т заасан “ЦШС-ШҮ-ын албанд шугамын трассын дагуу туулах чадвартай автомашин худалдаж авах” арга хэмжээний хүрээнд “Таван богд” ХХК-д 130.0 сая төгрөг шилжүүлэн урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4 дэх “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТЕЗ-ийн харьяа ОНӨААН-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

5. Аймгийн ИТХ-ын 2021.06.29-ны өдрийн хуралдааны 3/12 дугаар “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор 5,262.9 сая төгрөгийн 21 төрлийн ажлын хэрэгжүүлэхээр уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг 15 аж ахуйн нэгжтэй 9,150.0 сая төгрөгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулж 3,361.4 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн ч хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, эрх бүхий эзэмшигчийг тогтоолгож хөрөнгөд бүртгэх.

Зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны дотор, холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Хавсралт 1.:Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо 2021	Аудитын нэр:	Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:		
			БНА-2022/1/НА-СТА-ТЕЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянхонгор аймгийн Засаг дарга		сая төгрөг	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд Богд сумын ЗДТГ-ын 9.0 сая төгрөгийн үнэ бүхий худаг, 8.0 сая төгрөгийн үнэ бүхий үерийн даланг зам гүүрний байгууламж дансанд нэгтгэсэн.	17.0	Санхүүгийн тайланд залруулга хийсэн	Аймгийн Засаг дарга СТСХ-ын дарга Аймгийн Ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
2	Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд Баянхонгор сумын ИТХ-ын тайлант онд суутгасан 6.4 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг үлдэгдлээр нэгтгэсэн.	6.4	Санхүүгийн тайланд залруулга хийсэн	Аймгийн Засаг дарга СТСХ-ын дарга Аймгийн Ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
3	Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд Баян-Өндөр сумын цэцэрлэг, Бөмбөгөр сумын соёлын төвийн барилгын өргөтгөл, их засварын барьцаа 38.4 сая төгрөгийн өглөгийг дутуу бүртгэсэн.	38.4	Санхүүгийн тайланд залруулга хийсэн	Аймгийн Засаг дарга СТСХ-ын дарга Аймгийн Ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
4	Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-ийн төсөл хөтөлбөрт олгосон зээлээс суутгасан хяналтын зардал 124.1 сая, түрээслэгчдээс урьдчилж авсан нэг сарын түрээсийн төлбөр 9.9 сая нийт 134.0 сая төгрөгийн урьдчилж орсон орлогыг урт хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн.	134.0	Санхүүгийн тайланд залруулга хийсэн	Аймгийн Засаг дарга СТСХ-ын дарга Аймгийн Ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
5	Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зураг төсвийн авлагын үлдэгдлийг 31.8 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн.	31.8	Санхүүгийн тайланд залруулга хийсэн	Аймгийн Засаг дарга СТСХ-ын дарга Аймгийн Ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
6	Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд төсөвт байгууллагуудад олгох нэмэлт санхүүжилтийн 237.0 сая төгрөгийн өглөгөөс 119.7 сая төгрөгийн өглөгийг тусгаж 117.3 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй.	117.3	Санхүүгийн тайланд залруулга хийсэн	Аймгийн Засаг дарга СТСХ-ын дарга Аймгийн Ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
7	Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдын ЗДТГ-ын хөрөнгөд тус бүр 920.0 сая төгрөгөөр бүртгэлтэй сэргээгдэх эрчим хүчний байгууламжуудын хөрөнгөөс зарим хэсэг нь ашиглалтгүй болсон, эвдэрсэн байхад анх хөрөнгийг бүртгэхдээ нэр төрлөөр нь үнэлж бүртгээгүйгээс эвдэрсэн хөрөнгүүд данс бүртгэлээс хасагдаагүй байгаа тул хөрөнгийг нэр төрлөөр нь зөв ангилж бүртгэн, ашиглалтгүй хөрөнгүүдийг холбогдох байгууллагын шийдвэрийг гаргуулж данснаас хасах зөвлөмжийг өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргад хүргүүлсэн ч хэрэгжээгүй байна.	0	Албан шаардлага хүргүүлэв	Аймгийн Засаг дарга СТСХ-ын дарга Аймгийн Ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
